МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2020.01.14 № 01/128

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу яамны хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдааны тэмдэглэлийн хамт хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 10 хуудастай.

Х.БАДЕЛХАН

151040053

БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2020 оны 01 дугаар сарын 23 № 01 Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу барилга, хот байгуулалт, газрын харилцааны салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хэлэлцсэн тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Барилга, хот байгуулалт, газрын харилцааны салбарт мөрдөж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг баталгаажуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх;

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлж, яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, газар, хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2020 оны эхний хагас жилд багтаан хэрэгжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгох.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

151090091

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

2020.01.09 Улаанбаатар хот

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Барилга, хот байгуулалтын сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, Засгийн газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг тайлагнах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгон журмын 6.3-т заасан аргачлалыг баримталсан.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2019 оны жилийн эцсийн байдлаар 2 хуулийн 3 заалт, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт, Улсын Их Хурлын 4 тогтоолын 8 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2 тогтоолын 4 заалт, Засгийн газрын 36 тогтоолын 45 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 6 заалт, Засгийн газрын хуралдааны 24 тэмдэглэлийн 38 заалт, Засгийн газрын 4 албан даалгаврын 9 заалт буюу нийт 77 шийдвэрийн 115 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан.
Эдгээрээс бүрэн хэрэгжсэн буюу 100%-тай 95, хэрэгжих шатанд байгаа буюу 70%-ийн хэрэгжилттэй 13, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 1, хугацаа болоогүй 4, хэрэгжээгүй 1 заалт байгаа бөгөөд хэрэгжилт 94,05%-тай байна. Хангалтгүй хэрэгжиж буй тогтоол, шийдвэрийн жагсаалтыг хавсаргав. /Хавсралт 1/

Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Барилга, хот байгуулалтын сайдад үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч ажилласан. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдалд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн яамны газар, хэлтсийн ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглаж байна. Мөн 2019 оны эхний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Сайдын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэр, эрчимжүүлэн ажиллах арга хэмжээний жагсаалтын хамт ЗГХЭГ-т 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/2511 тоотоор хүргүүлэн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д байршуулан, баталгаажуулсан. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хийсэн ажлын тайланг улирал тутам тогтоосон хугацаанд Засгийн газрын хяналт-

шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д байршуулан, баталгаажуулж ажилласан.

ЗГХЭГ-аас тус яамны 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагналт өмнөх оны мөн үеэс сайжирсан гэж дүгнэсэн. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулж, үр дүнгийн үзүүлэлтийг өсгөх зорилгоор Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын талаарх сургалтыг ЗГХЭГ, Удирдлагын академтай хамтран яам болон харьяа байгууллагынхаа албан хаагчдад 2 удаа явуулснаар төлөвлөлт оновтой болж, хэрэгжилтэд ахиц гарсан. Үүнтэй холбоотой тайлагнах үйл явцын давтамж, чанарт ахиц гарсан.

2. Өмнө нь гарсан шийдвэр, заалтыг хагас жилийн байдлаар нэг бүрчлэн шүүж, хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасуулсан.

3. Тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй, эсхүл үнэлэх боломжгүй заалтыг цаашид боловсронгуй болгох үүднээс Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу салбарын хууль тогтоомжийг бүхэлд нь судалж, чиг үүргийн давхардал, хийдэл, зөрчил байгааг илрүүлэн холбогдох хуулиудад энэ асуудлаар оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулж тусгуулсан.

Тус салбарын хэмжээнд 10 чиг үүрэгт хамаарах давхцал байгааг чиг үүргийн шинжилгээний үр дүнд илрүүлсэн. Тухайлбал: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн чиг үүргийн хүрээнд-5, Орон сууц, инженерийн шугам сүлжээ нийтийн аж ахуйн чиг үүргийн хүрээнд-5, Мөн салбарын 7 чиг үүрэгт хамаарах асуудлыг дахин хуваарилах шаардлагатай байв. Тухайлбал: Хот байгуулалт-2, Барилга, барилгын материал-3, Газар зохион байгуулалт, геодези зураг зүй-2. Хот байгуулалт, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц шаардлагатай байсан.

4. Тайлант хугацаанд бусад газар хэлтсүүдтэй харилцан уялдаатай ажиллаж, тайлан биелэлт ирүүлэх талаар арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласны үр дүнд өмнөх онтой харьцуулахад тайлагнах ур чадвар тодорхой түвшинд ахисан.

5. Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүд, дүрэм журмын хэрэгжилтийг хянах, сайжруулах, төрийн байгууллагууд, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор төрийн албан хаагч бүрийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчилж, холбогдох үүргийг тодорхой тусган биелэлтэд сар бүр хяналт тавьж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /www.unelgee.gov.mn/-д байрлуулж, сар бүр хугацаанд нь баталгаажуулан хүргүүлж хэвшсэн.

6. 2018 онд Шударга байдлын үнэлгээгээр тус яам доогуур үнэлгээ авсан тул Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан нийслэлийн хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц,

нийтийн аж ахуйн салбарын албан хаагчдад зориулсан “Шударга ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар , Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Нийслэлийн захиргааны 5 дугаар байранд зохион байгуулсан. Сургалтын үеэр “Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ? түүний мөн чанар” сэдвээр Улсын Ерөнхий Прокурорын газрын Сургалтын төвийн ахлах прокурор, Хууль цаазын шадар зөвлөх, доктор (Ph.D) Б.Өнөрмаа, “Монголын төрт ёсны түүхэн уламжлал төрийн түшээдийн ёс зүйтэй холбогдох нь” сэдвээр Удирдлагын академийн багш, доктор (Ph.D), профессор Т.Лхагваа, “Төрийн байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдвээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын референт С.Нямбаяр, “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх нь” сэдвээр Удирдлагын академийн багш, доктор (Ph.D) М.Амартүвшин нарыг урьж лекц уншууллаа.

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн**

Хүснэгт-1

| Үзүүлэлт | | Бүгд | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хууль | Ерөнхийлөгчийн зарлиг | УИХ-ын тогтоол | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын албан даалгавар | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл |
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | 77 | 2 | 1 | 4 | 2 | 36 | 4 | 4 | 24 |
| Хяналтад авсан нийт заалтын тоо | | 115 | 3 | 2 | 8 | 4 | 45 | 6 | 9 | 38 |
| Үүнээс | Бүрэн хэрэгжсэн 100% | 95 | 1 | 2 | 5 | 3 | 38 | 5 | 7 | 33 |
| | Хэрэгжих шатанд 70% | 13 | 2 | - | 1 | - | 6 | 1 | 1 | 3 |
| | Хэрэгжилт хангалтгүй 30% | 1 | - | - | - | - | - | - | - | 1 |
| | Хэрэгжээгүй 0% | 2 | - | - | 1 | 1 | - | - | - | - |
| | Хугацаа болоогүй | 4 | - | - | 1 | - | 1 | - | 1 | 1 |
| | Хүчингүй болсон | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Биелэлтийн дүн /хувь/** | | **94,05%** | **80%** | **100%** | **81.4%** | **75%** | **95.9%** | **95%** | **96,2%** | **95,6** |

**Гурав. Дүгнэлт**

**Нэг. БХБЯ нь 2019 оны жилийн эцсийн байдлаар дараах томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:**

***1. 2018_43. Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай***

*1.17. иргэдийн орлогод нийцсэн хямд өртөгтэй орон сууц болон түрээсийн орон сууц барихад шаардагдах хөрөнгийг зориулалтын сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;*

Тус яам Засгийн газрын 2019 оны 6 дугээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолыг батлуулснаар ТОСК ХХК-ийн санхүүжилтгүйн улмаас зогссон орон сууцнуудыг Хөгжлийн банкны санхүүжилтээр барьж дуусган Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон сууцыг барьж түрээсийн орон сууцны санг бүрдүүлсэн. "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ын төслийг боловсруулж 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын 138 дугаар тогтоолоор батлуулсанаар зах зээлд түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэнд өмчлүүлэхээр хэрэгжиж буй 3457 айлын орон сууц байгаагаас 2387 айлын орон сууцанд иргэдийг хамруулсан. БНСУ-ын Экспорт-Импорт банкны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /EDCF/-ийн Үнэлгээний ажлын хэсэг, Сангийн яам, "ТОСК" ТӨХХК-тай хамтран "Солонго 1, 2 орон сууцны хороолол барих" төслийн зээлийн гэрээнд тусгах "Хэлэлцээрийн тэмдэглэл"-ийг эцэслэн боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр албажуулан, талууд гарын үсэг зурж баталгаажуулсан. 2020 оны 1 дүгээр сард багтаан Зээлийн хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.
2019 оны 7 дугаар сард "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт БХБЯ-ын ТНбД, БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн албаны дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Тус ажлын хүрээнд "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн барилга угсралтын ажлын бэлтгэл хангах төлөвлөгөө /2019-2020/-г ТНбД-аар 2019 оны 7 дугаар сард батлуулсан. Төслийн барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Интеллект тауер" ХХК шалгаран ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 11 дүгээр сарын 01-нд зураг төслийг боловсруулан батлуулж, эх хувь материалыг хүлээлгэн өгсөн. Барилгын зураг төслийн дагуу барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Тендерийн баримт бичгийг боловсруулах ажлыг Төсөл хэрэгжүүлэх нэгж хариуцан гүйцэтгэж байна. Барилгын ажил 2020 онд эхэлнэ.

**2. 2018_73. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2018-03-14 / ЗГ-ын тогтоол**

*3.Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх, холбогдох үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт үүрэг болгосугай.*

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Монгол ТВ, Ийгл ТВ-үүдэд ярилцлага өгч, цахим сүлжээгээр шторк бэлтгэн явуулж, БХТ-тэй хамтран Барилгын мэдээлэл нэвтрүүлэг дугаар 1, 2-ийг бэлтгэн мэдээллийг ТВ болон БХТ-ийн гадна дэлгэцээр олон нийтэд танилцуулга хийсэн.

ТНБД-ын 2018 оны 11 сарын 27-ны өдрийн А/182 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх" арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж

тайланг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.

**3. 2019_3. 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 дугаар тэмдэглэл / 2019-01-16 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл**

*Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;*

Барилга хот байгуулалтын салбарт Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал” хэрэгжүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын салбарын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 56 дугаар тушаалаар баталсан. Энэхүү ажлын хэсэг нийт 14 гишүүнтэй бөгөөд байгуулагдсанаас хойш 11 удаа хуралдаж, 3 удаа вакумжин ажилласан. Ажлын хэсэг нь чиг үүргийн шинжилгээ хийх хүрээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа 200 гаруй хуулийг судлав. Эдгээрээс тус салбарт хамаарах асуудлыг шууд зохицуулсан 20, салбарт хамаарах асуудлыг бусад хуулиар зохицуулсан 47, төрийн захиргааны төв байгууллагын хувьд хамаарах нийтлэг чиг үүрэг /эрх хэмжээ ба үүрэг/-ийг тодорхойлсон 65 хууль байсан. Барилга, хот байгуулалтын яам 2 ерөнхий, 5 үндсэн, 43 дэд чиг үүрэгтэй. Засгийн газрын 2018 оны 1-р сарын 24-ний 22 дугаар тогтоолоор баталсан Аргачлалын 3-р хавсралтад заасан санал асуулгын хуудсыг салбарын мэргэжилтнүүдээр бөглүүлэн авч дүгнэлт өгсөн бөгөөд, улмаар хэлэлцүүлэг зохион байгуулж, чиг үүргийн давхардлыг арилгах, дахин хуваарилах саналыг эцэслэн боловсрууллаа. Тайлант хугацаанд тус ажлын хэсэгт Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслөөс арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байсан бөгөөд Санхүүгийн үр дагаварыг тооцох сургалтыг зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүд салбарын санхүү хариуцсан мэргэжилтнүүд оролцсон. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дахь Зөвлөлдөх ажлын хэсэгт чиг үүргийн шинжилгээ хийж, дахин хуваарилах санал боловсруулах ажлын явц байдлын талаар 3 удаа тайлан хэлэлцүүлсэн.

**4. 2019_36. 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр 36 дугаар тэмдэглэл**

*XYI.5. . Аюултай хог хаягдал, лагийн төвлөрсөн байгууламж барих зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авахад тулгамдаад байгаа асуудлын талаар Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан аюултай хог хаягдлын болон лаг боловсруулах төвлөрсөн байгууламж барих зориулалтаар нийслэлийн Багануур дүүргийн нутаг дэвсгэрт 10 га газрыг, Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт 20 га газрыг тус тус улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг боловсруулан Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгав.*

Нийслэлийн Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 10 га, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Төв цэвэрлэх байгууламж”-ийн дэргэд 22 га газрыг аюултай хог хаягдал, лаг боловсруулах, булшлах, устгах байгууламж барих зориулалтаар тус тус улсын тусгай хэрэгцээнд авч Засгийн газрын 2019 оны 337 дугаар тогтоолоор батлуулсан.

**5. 2019_23. 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай**
*Хавсралтаар төлөвлөгөөг оруулав.. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан "ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана.*

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан яамны дотоод бүтцийн нэгж, харьяа газар, байгууллагуудад тараан хэрэгжилтийг хяналтад авч үнэлэн тайланг улирал бүр тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д байршуулан, баталгаажуулсан. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээг дурдвал:

- ГЗБГЗЗГ нь салбарын хэмжээнд 2019 оныг "Иргэн төвтэй ил тод ухаалаг газрын харилцааны жил" болгон газрын харилцаатай холбоотой бүхий л үйлчилгээг иргэдэд ойртуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр хүчин чармайлт гарган ажиласан.
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн системийн геопортал geoportal.nsdi.gov.mn хуудасны Webappbuilder платформыг ашиглан орон зайн өгөгдлүүдийг олон нийтэд гаргах, гаргасан өгөгдлөөс засаг захиргааны хил болон бусад орон зайн давхаргаар хайлт шүүлт хийж, хэвлэх боломжийг бүрдүүлсэн. Геопорталын Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем нь ArcGIS сервер (ArcGIS server manager), өгөгдлийн сан (ArcGIS Datastore), Веб газрын зургийн (Enterprise site) гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэн ажиллаж байгаа бөгөөд ArcGIS серверт орон зайн өгөгдлийн суурь 16 төрлийн мэдээлэл, дэд ангиллууд агуулагдаж байна. 16 давхаргад агуулагдах мэдээллийг веб үйлчилгээнд гаргаж, суурь давхаргуудын мэдээллийг хянах, удирдах, тайлан гаргах системийг хөгжүүлсэн.

Дээр дурдсан газрын үнэлгээтэй холбоотой бүх мэдээллүүдийг иргэд, олон нийт www.egazar.gov.mn хаягнаас харах мөн төрийн үйлчилгээний танилт нэвтрэлтийн ДАН системээр нэвтрэн өөрийн газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийг харах, эргээд төрийн үйлчилгээнд хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

**6. 2019_29. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай / 2019-01-16 / ЗГ-ын тогтоол**
*3.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2016 оны 174 дүгээр тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга (Ж.Батбаясгалан) нарт даалгасугай.*

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" баримт бичгийн хэрэгжилтийн байдал, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний УБ бүс нутаг, хот орчмын судалгаа"-ны ажил, "Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци"-ийг архитектурын

мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар нээлттэй хэлэлцүүлсэн. Хурлаас өгсөн саналыг тусган НИТХТэргүүлэгчдэд 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр танилцуулсан. Хуралдаанаас НИТХ-аар хэлэлцүүлэх, мөн намын бүлгүүдээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу НИТХ-ын дэргэдэх намын бүлгүүдийн хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр, НЗД-ын дэргэдэх “Аз жаргалын хороо”-ны хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, НИТХурлаар 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр тус тус хэлэлцүүлж НИТХ-ын гишүүдээс санал авсан. Хуралдаанаас НИТХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан санал өгөх ажил зохион байгуулагдаж НИТХ-аар 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хэлэлцүүлж 28/26 дугаар тогтоолоор дэмжигдсэн.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн хэрэгжилтийн байдал, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний УБ бүс нутаг, хот орчмын судалгаа”-ны ажил, Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ажлын хүрээнд БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-аар 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцүүлж, гишүүдээс гарсан саналуудыг тусган БХБ-ын сайдын зөвлөлийн 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж ЗГ-т хүргүүлэхээр шийдвэрлэсний дагуу саналыг нэгтгэн бэлтгээд байна.

**7. 2019_29. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай / 2019-01-16 / ЗГ-ын тогтоол**

*4.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан шинэ хот /Аэросити/-ын инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, эх үүсвэрийг барьж байгуулахад шаардагдах зардлыг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, нийслэлийн Засаг дарга (Ж.Батбаясгалан) нарт үүрэг болгосугай.*

Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБСайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 тоот тушаалаар байгуулсан.

-Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хийхэд шаардлагатай 783.8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах

гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБСайдын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/158 тоот тушаалаар байгуулсан.

**8. 2019_277. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай**

*2.Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтооход шаардагдах зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.*

Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 07 дугаар сарын 03-ны өдрийн 277 дугаар тогтоол, "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 1, 9 дүгээр хавсралтыг удирдлага болгон ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/100 дугаар тушаал болон холбогдох бусад тушаалаар яамны албан хаагчдыг ажил, албан тушаалд томилж, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг дээрх тогтоолын дагуу 2019 оны төсөвт багтаан шийдвэрлэсэн. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсантай холбоотой гарч болзошгүй нэмэлт зардлыг 2020 оны төсвийн төсөлд тооцон тусгуулж батлуулсан. 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн яамны зарим албан хаагчдын цалингийн шатлал ахиулах асуудлыг шийдвэрлүүлэхээр саналын төсөл боловсруулагдаж байна.

**9. 2018_21. 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл**

*XXIX.2. 4. . Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцон ажиллахыг төрийн байгууллагын удирдлагуудад даалгав.*

Барилга, хот байгуулалтын сайдын 05 дугаартай албан даалгаврыг 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдөр баталж, Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 03/3223 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /ГЗБГЗЗГ/, Төрийн орон сууцны корпораци /ТОСК/, Барилгын хөгжлийн төв /БХТ/-д хүргүүлж , биелүүлж ажиллах чиглэл, зөвлөмжийг өгч, хугацааны эцэст хэрэгжүүлсэн ажлыг заалт бүрээр гаргуулан тайланг нэгтгэж ЗГХЭГ-т хүргүүлсэн. Сайдын албан даалгавар нь нийт албан хаагчид болон харьяа байгууллагын хувьд дотоод журмын адил үйлчлэх тухай анхааруулсныг мөн тайлбарлан хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон. Дээрх үүрэг даалгаврыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хяналт тавин ажилласан.

**10. 2018_35. 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр 35 дугаар тэмдэглэл**

*XIX.4. . "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газарт хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах асуудлын талаар Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хуралдаан дээр Засгийн*

*газрын гишүүдээс гаргасан саналын дагуу “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын захиалгаар барьж, төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг шийдвэрлэх тодорхой санал боловсруулан танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Ж.Хичээнгүй нарт даалгав.*

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны 23 дугаар тогтоолоор “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаардлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг баталсан. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн Барилга, хот байгуулалтын сайдын урсгал зардлын багцад 5.0 тэрбум төгрөг тусгагдсан. Энэхүү санхүүжилтаар “ТОСК” ТӨХХК-ийн МУХБ-д төлөх өрийг барагдуулна.

**2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэх явц удаашралтай буюу 30 хувьтай байна.**

**2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр 23 дугаар тэмдэглэл / 2019-05-22 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл**

*YII.2.“Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК-ийн орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны арилжааны орлогоос орон сууцны зээлийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авахыг Монголбанк (Н.Баяртсайхан), Санхүүгийн зохицуулах хороо (С.Даваасүрэн)-нд зөвлөж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт даалгав.*

Барилга, хот байгуулалтын яамны хүсэлтийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 онд хийх төлөвлөгөөт шалгалтын хуваарьт оруулж, II улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

**3.Хугацаа болоогүй дараах 4 арга хэмжээ байна. Үүнд:**

***1. 2015_36. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай / 2015-02-17 / УИХ-ын тогтоол***

*6/аймгийн төвийн сумдыг татан буулгаж, аймгийн төвийг хот болгох асуудлыг 2017 оноос эхлэн хэрэгжиж эхлэхээр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;* тайлан хавсаргав.

***2. 2018_232. Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай / 2018-08-01 / ЗГ-ын тогтоол***

*Улсын хилийн зурваст боомтын зориулалттай төмөр зам барих барилгын ажлын зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хилийн боомтын үндэсний зөвлөл (Х.Хүрэлбаатар)-д тус тус даалгасугай.*

***3. 2019_34. 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл / 2019-08-07 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл***

*XIY.3. . “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” барих газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар холбогдох саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг*

*Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Нийслэлийн Засаг дарга С.Амарсайхан нарт үүрэг болгов.*

***4. 2019_03. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай / 2019-10-16 / ЗГ-ын албан даалгавар***

*3.Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд.*

**4.Хэрэгжээгүй 0 хувьтай дараахь арга хэмжээ байна.**

***2013.02.07 №20. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2013-02-07 / УИХ-ын тогтоол***

***1.2.. Барилгын ажил эрхлэх аливаа зөвшөөрөл /техникийн нөхцөл, дүгнэлт зэрэг/, тусгай зөвшөөрөл олгосон байдал, түүнчлэн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, нэгдсэн эмнэлгийн эдэлбэр газарт барилга байгууламж барих зөвшөөрөл олгосон асуудлыг хууль, хяналтын байгууллагын оролцоотой ажлын хэсэг байгуулан шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах***

## Дөрөв. Санал, зөвлөмж:

1. Холбогдох газрын дарга нар хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан хэрэгжилт хангалтгүй 0% ба 30%-тай хөрөнгө оруулалт, санхүүжилт шаардагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой үүрэг, даалгаврыг 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг яаралтай авч ажиллах,

2. Хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдэгдээгүйгээс удаашралтай байгаа тодорхой ахиц гаргаагүй үүрэг, даалгаврыг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж, Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

3. Бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, ач холбогдолгүй болсон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүчингүй болгох санал боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, Төрөөс баримтлах бодлогуудад нэмэлт өөрчлөлт оруулахдаа эдгээртэй холбоотой өмнө гарсан тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах асуудлыг давхар шийдвэрлэх;

4. Арга хэмжээний биелэлтийг гаргахдаа зөв оновчтой томьёолж, үр дүнгээ үнэн зөв, хугацаандаа тайлагнаж хэвших;

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлж, яамны болон харьяа байгууллага, газар, хэлтэс, мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой тусган, хэрэгжилтийг хангаж, дүнг улирал тутам тайлагнаж ажиллах;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Барилга, хот байгуулалтын яам

2019 оны жилийн эцэс

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | |
| 1 | 1 | БАРИЛГЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2016-02-05 Дугаар 16-04 | 14.9. .Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацаа тогтоох талаар холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаас стандарт болгох шаардлагатай гэсэн шийдвэр гарсаны дагуу боловсруулалтыг эцэслэн Стандартчилал хэмжил зүйн хороонд БХТ-ийн захирлын 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 1/733 тоот албан тоотоор хүргүүлсэн.<br>Стандарт хэмжил зүйн газрын барилгын техникийн хороогоор 2019 оны 10-р сарын 17-ны өдөр хэлэлцэгдэж гишүүдээс санал авч төсөлд тусгах шийдвэр гарсан.<br>Барилгын хөгжлийн төвөөс MNS 1:1-2006 стандартын 5.2.2-т заасны дагуу "Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага" стандартын төсөлд холбогдох байгууллагуудаас санал авахаар 2019 оны 11 дүгээр сарын 15-нд 1/3403 тоот албан бичгийг хүргүүлсэн. Саналыг авч байна. | 70% | |
| 2 | 2 | Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Дугаар 2017.05.12 | 8.2.1.. 8.2.Хог хаягдлын талаар зам тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.2.1. Тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих; | Журмын төслийг боловсруулан 2019 оны 5 дугаар сарын 22-нд холбогдох мэргэжлийн холбоод болон ТББ-аас ирүүлсэн саналыг үндэслэн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой олон улсын байгууллагатай хамтран 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хогийн цэгүүд, дахин боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж журамд нэмэлтээр оруулах саналыг хэлэлцсэн. 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр төрийн болон ТББ-ын төлөөлөлтэй журамд нэмэлтээр оруулсан саналын тухай хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр журамд дахин оруулах саналын хэлэлцүүлгийг Нийслэлтэй хамтран зохион байгуулж, "Барилгын хог хаягдлын тухай журам"-ын төслийг Каритас Чех Репаблик олон улсын байгууллагатай хамтран боловсруулж сайдаар батлуулахад бэлэн босон.<br><br>Хавсралт : 1 файл | 70% | |
| | 3 | | 8.2.2.. Энэ хуулийн 8.1.10-т заасан аргачлалын дагуу барилгын хог хаягдлын норматив хэмжээг тогтоох; | Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрмийн MNS BS 5906:2015 стандартыг 2018 онд батлуулсан. Уг стандартад барилгын хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, тээвэрлэлтийн талаар тусгасан. Энэхүү стандартаар барилгын хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, тээвэрлэлтийн асуудал зохицуулагдсан<br>Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12/-д БХБСайдын 2018 оны 09 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж барилгын 1м2 талбайд ногдох барилгын дахин хэрэглэгдэхгүй хог хаягдлын нормативыг төсвийн суурь үнэлгээнд оруулж өгсөн.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |
| УИХ-ын тогтоол | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 4 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2013-02-07<br>Дугаар 2013.02.07 №20 | 1.2.. Барилгын ажил эрхлэх аливаа зөвшөөрөл /техникийн нөхцөл, дүгнэлт зэрэг/, тусгай зөвшөөрөл олгосон байдал, түүнчлэн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, нэгдсэн эмнэлгийн эдэлбэр газарт барилга байгууламж барих зөвшөөрөл олгосон асуудлыг хууль, хяналтын байгууллагын оролцоотой ажлын хэсэг байгуулан шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах; | Барилгын ажил эрхлэх холбогдох зөвшөөрлийг Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоол, 2018 оны 317 дугаар тогтоол БХБС-ын 2018 ны 217 дугаар тушаал болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж байгаа бөгөөд Боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй буй барилга бүтээн байгуулалтын ажилд "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГазар хяналт тавин ажиллаж байна.<br>Дээрх ажлын хүрээнд ЗГ-ын 2017 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-д холбогдох заалтуудыг тусгаж батлуулсан. Үүнд: Дүрмийн 2.6. Зөвшөөрөл олгох байгууллага дараах үндэслэлээр барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай захиалагчид бичгээр хүргүүлнэ: 2.6.2. баримт бичиг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага (гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон өргөх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын тусгай зөвшөөрлийн болон техникийн нөхцөлийн хугацаа дуусгавар болсон, байршил, газар олголт, төлөвлөлтийн болон норматив баримт бичгийн шаардлагыг зөрчсөн)-д нийцээгүй. /ЗГ-ын 2017 оны 171-р тогтоолоор нэмэлт орсон/ зэрэг заалтыг нэмж тусган батлуулсан. | 0% | | |
| | 5 | | 1.11.. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн барилга, уул уурхай, эрчим хүч, зам, тээвэр, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажил олгогч, ажилтанд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулдаг болох, үүнтэй холбогдуулан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөц, зардлын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах; | Барилгын салбарт ажиллаж буй ажилтан албан хаагчдад ХАБЭА-н сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Барилгын салбар дахь "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 7 дугаар зөвлөгөөн-2019"-ийг 4 дүгээр сарын 1-ний өдөр зохион байгуулсан. Тус зөвлөгөөний хүрээнд ХАБЭА-н сарын аяны нээлтийн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нэг сарын хугацаатай ХАБЭА-н бодит ажлуудыг хэрэгжүүлсэн. Тус зөвлөгөөнд барилгын салбарын 300 гаруй ХАБЭА-н ажилтан, инженер техникийн ажилчид, удирдлагууд оролцсон. Мөн Барилгын салбарын ХАБЭА-н сарын аяны хүрээнд "Барилгын салбарын ХАБЭА-н ажилтнуудад зориулсан аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалтыг "Оюу толгой" ХК-тай хамтран Барилгын хөгжлийн төвд 4 дүгээр сард 2 удаа зохион байгуулсан. Барилгын салбар дахь ХАБЭА-н чиглэлээр Япон Улсын Засгийн газрын JICA байгууллагатай хамтарсан "Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийг төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд салбарын хүний нөөцийг чадавхижуулах, сургалтын хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэх, холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулах ажил хийгдэж байна. Тухайлбал: "Барилгын ажлын өндрийн аюулгүй ажиллагаа", "Барилгын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мөчлөг", "Барилгын ажлын сайн ба муу жишээ" зэрэг гарын авлагуудыг боловсруулсан. Мөн төслийн хүрээнд ХАБЭА-н жишиг танхим, ХАБЭА-н лаборатори байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% | | |
| 4 | 6 | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай<br>2013-02-08<br>Дугаар 02_2013_23 | 2.5. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг мөрдөн ажиллаж, биелэлтийг хоёр жил тутам гаргаж Улсын Их Хуралд танилцуулж байх. | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" барим бичгийн хэрэгжилтийн байдал, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний УБ бүс нутаг, хот орчмын судалгаа"-ны ажил, "Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци"-ийг архитектурын мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар нээлттэй хэлэлцүүлсэн. Хурлаас өгсөн саналыг тусган НИТХТэргүүлэгчдэд 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр танилцуулсан. Хуралдаанаас НИТХ-аар хэлэлцүүлэх, мөн намын бүлгүүдээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэний дагуу НИТХ-ын дэргэдэх намын бүлгүүдийн хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр, НЗД-ын дэргэдэх "Аз жаргалын хороо"-ны хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, НИТХурлаар 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр тус тус хэлэлцүүлж НИТХ-ын гишүүдээс санал авсан. Хуралдаанаас НИТХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан санал өгөх ажил зохион байгуулагдаж НИТХ-аар 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хэлэлцүүлж 28/26 дугаар тогтоолоор дэмжигдсэн.<br>"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" барим бичгийн хэрэгжилтийн байдал, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний УБ бүс нутаг, хот орчмын судалгаа"-ны ажил, Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ажлын хүрээнд БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-аар 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцүүлж, гишүүдээс гарсан саналуудыг тусган БХБ-ын сайдын зөвлөлийн 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж ЗГ-т хүргүүлэхээр шийдвэрлэсэн. | 70% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | 7 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2015-02-17<br>Дугаар 2015_36 | 6. 6/аймгийн төвийн сумдыг татан буулгаж, аймгийн төвийг хот болгох асуудлыг 2017 оноос эхлэн хэрэгжиж эхлэхээр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Хот, тосгоны эрх зүйн орчныг судлан, "Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоох тухай" УИХ-ын тогтоолын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайланг дахин хянаж боловсруулсан. Үнэлгээний тайланд уг асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах нь илүү үр нөлөөтэй бөгөөд гагцхүү Үндсэн хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах, "Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-өөр аймгуудын нийгэм-эдийн засгийн таталцал, орон нутгийн хөгжлийн чадавхи, нөөцөд тулгуурлан аймаг, сумдын бүлэг суурингийн тогтолцоо буюу сумдын бүсчлэл, сум дундын төвүүдийг тогтоох чиглэлийг судалсанаар шийдвэрлэх нь тохиромжтой гэсэн дүгнэлт, зөвлөмж гарсан.  Иймд өнөөгийн мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчин, гадаад, улс орнуудын хотын удирдлагын үндсэн зарчим, тогтолцоог харьцуулан судалсан тандан судалгааны тайланг танилцуулж, хотуудад улсын зэрэглэл тогтоох асуудлыг УИХ-ын тогтоол гаргаснаар бүрэн шийдвэрлэх боломжгүй гэсэн дүгнэлт, зөвлөмж гарсантай холбогдуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх боломжгүй болсон. Өөрөөр хэлбэл өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль эрх зүйн орчны хүрээнд хотын зэрэглэлийн асуудал зөрчилтэй байгаа тул УИХ-ын тогтоолоор шийдвэрлэх боломжгүй. | Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй | |
| | 8 | | 3. газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах; | Тус яам Онцгой байдлын ерөнхий газар, Одон орон геофизик судалгааны хүрээлэнтэй хамтран баталсан 2018 оны 2018/175 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу 2018 онд эхлүүлсэн "Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи,гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил"-ыг үргэжлүүлэн хийхэд шаардлагатай 2 тэрбум төгрөгнөөс 2019 оны улсын төсөвт 400.0 сая төгрөг суусан. Эхний шатны тайланг 2018 онд хүлээн авсан ба хоёрдугаар шатны тайланг 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 53 тоот албан бичгээр авч, захиалагчийн хяналтыг хийхээр Газар, зохион байгуулалт геодези зураг зүйн газарт 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 03/1184 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Захиалагчийн хяналт хийсэн тухай албан бичгийг 05 дугаар сарын 23-ны өдрийн 1/1017 тоот албан бичгээр хүлээн аваад байна. Мөн 2020 оны Төсвийн тухай хуулинд шаардлагатай байгаа үлдэгдэл санхүүжилтийн төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. Гэвч 2020 оны төсөвт тусгагдаагүй.<br>Мөн энэ арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн орчны шинэчлэл хийгдэж байгаа бөгөөд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гамшиг, газар хөдлөлийн талаар тодорхой зүйл, заалтуудыг тусгасан.Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө"-ний баримт бичгийг баталсан. Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад , бүсийн хүн амыг 2030 онд 1763.0 мян байхаар тооцож дагуул хот тосгодын хүн ам 171.5 мянга болж өсөхөөр тооцоолж Багануур, Багахангай, Оюутны хотхон (шинэ хот), Аэросити (шинэ хот) зэрэг дагуул хот, тосгодыг тодорхой чиглэлийн үйлдвэр, худалдаа үйлчилгээ дагнан хөгжүүлэхээр тусгасан.  Үүний дагуу Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулаад байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | 9 | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2016-04-14<br>Дугаар 34-16-05 | 4. энэ тогтоолын 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэн байрлуулах саналыг боловсруулж 2016 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах; | "Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж холбогдох баримт бичгийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд 2018 оны УИХ-д танилцуулсан. Мөн "Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт төрийн ордны барилгыг шинээр барих болон хуучин барилгыг хүчитгэхэд шаардлагатай судлагаа, тооцоо, түүнчлэн Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэх саналыг дахин боловсруулж шаардлагатай санхүүжилтийн тооцооны хамт Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 21-ний хурлаар хэлэлцүүлсэн. Дээрх судалгаа тооцоонд үндэслэн Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2020 оны төсвийн тухай хуулинд төрийн ордны барилгыг хүчитгэх, шинээр барих барилгын зураг төслийн санхүүжилтийг тусган Сангийн яаманд хүргүүлсэн байна. | 100% | |
| | 10 | | 5. орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгаа гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах; | Монгол Улсын хэмжээнд 2018 онд хийсэн судалгаагаар нийт 459 орон сууц, 52 цэцэрлэг, 65 сургууль, 70 эмнэлгийн барилга байгууламж газар хөдлөлтөд тэсвэргүй ашиглалтын шаардлага хангахгүй буулгаж шинээр барих шаардлагатай байна. Үүнээс 2019 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 75 орон сууцны барилга байгууламжийг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна. Мөн аймаг орон нутгийн хэмжээнд 6 орон сууц, 1 сургууль, 2 хичээлийн байр, 2 соёлын төв, 1 асрамжийн барилгыг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна. | 100% | |
| | 11 | | 6. барилга байгууламжийн хийц, бүтээц, эдлэхүүн, материал, түүхий эдийн бат бэх чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, техник технологийг туршин шалгах, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгдсэн лабораторийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллуулж, орон нутагт сүлжээ бий болгон өргөжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 2019 оны улсын төсөвт 240,0 сая төгрөгийг тусгуулсан. Улаанбаатар хотын Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн цалин, урсгал зардал, тоног төхөөрөмжийн хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр улсын төсөвт суулгах 750,0 сая төгрөг, бүсийн тулгуур төвүүдэд байгуулах 8 төрлийн лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн эх үүсвэр 340,0 сая, аймаг бүрт байгуулах 5 төрлийн лабораторийн 150,0 сая нийт 1.240,0 сая төгрөгийн эх үүсвэрийг жил бүр улсын төсөвт суулган төв болон орон нутгийн барилгын материалын лабораторийн төрлийг нэмэгдүүлэн өргөжүүлэхээр саналаа хүргүүлсэн. Мөн орон нутгийн лабораториудад орон тоог нэмэгдүүлэх ажлыг ГХГЗЗГ-т хүргүүлсэн. Лабортариудын ажлын уялдаа холбоо болон харилцан мэдээлэл солилцох чиглэлээр БХТ-ийн мэдээллийн сангийн сүлжээнд холбоод байна. Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх, орон нутгийн барилгын материалын лабораториуд, барилгын материалын үйлдвэрүүдийн үйл ажиллагааг бодлого, зөвлөмжөөр хангаж ажиллах зорилтын хүрээнд орон нутгийн лабораториудыг итгэмжлүүлэх, мэргэжилтэнг давтан сургах ажлыг СХГазартай хамтран хэрэгжүүлж байна. Барилгын материалын чанар аюулгүй байдлыг сайжруулах, зах зээлд худалдаалагдаж байгаа материалд хяналт тавих ажлаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран 2 удаа улирлын шалгалт хяналт хийж тайланг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Лабораторийн туршилт, шинжилгээ судалгааны үр дүнд хяналт хийх ажлыг мэргэжлийн хяналтын газар болон хөндлөнгийн лабораториудтай хамтран хийж байна.<br>Хятадын Стандартын байгууллага, СХЗГ-тай хамтран 2019 оны 12 дугаар сарын 2-4-ний хооронд холбогдох үйлдвэр, лаборатори, итгэмжлэлийн байгууллагуудад сурталчилан цементийн стандартыг таниулах арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд лабораторийн эрхлэгч, шинжээч 25 хүнтэй сургалт зохион байгуулсан. | 100% | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | 14 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2017-01-03<br>Дугаар 2017_01 | 15. Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх, барилгажуулах, хувийн тохилог сууцтай болгох асуудалд анхаарах | Хотыг хөгжүүлэх, барилгажуулах, хувийн тохилог сууцтай болох асуудалд анхааран дараах ажлыг хийгээд байна. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг дүгнэх хот байгуулалтын үнэлгээ", "Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцийн Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа"-ны ажлуудыг нэгтгэн боловсруулж байна. Хотыг хөгжүүлэх, барилгажуулах, хувийн тохилог сууцтай болох асуудалд анхааран дараах ажлыг хийгээд байна. 2018 оны Засгийн газрын 369 дүгээр тогтоолоор 120 м.кв хүртэлх талбайтай амины орон сууцанд 60 сая хүртэлх төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн. /150 мянган айл-орон сууц /Үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Ингэснээр Нийслэлийн 73,336 өрх, орон нутгийн 37,266 өрх өөрийн өмчлөлийн газартаа инженерийн хангамж бүхий амины орон сууц барих, нийслэлд 44,747 өрх, орон нутагт 32,048 өрх орон сууц түрээслэн амьдрах хэрэгцээ тодорхой хэмжээнд хангагдах нөхцөл бүрдэл бүрдэнэ. Хөтөлбөрт туссан амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд инженерийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх төслийг үе шаттай хэрэгжүүлж, орон сууцны хотхон хороолол, түүний нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Сервис центр" / Барилга, хот байгуулалтын яамнаас "Сервис центр" төслийг санаачлан салбарын инженерүүд, эрдэмтдийн санал, зөвлөгөөг тусган, төслийн ТЭЗҮ-ийг 2017-2018 онд боловсруулсан. / төслийг хэрэгжүүлж байна. | 100% | |
| | 15 | | 16. Гэр хорооллыг дахин төлөвлөх, барилгажуулах, хувийн тохилог сууцтай болгох асуудалд анхаарах | Монгол Улсын Хөгжлийн банкнаас Хятадын экспорт, даатгалын зээлийн корпорацитай Хамтын ажиллагааны гэрээг 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулав. Энэ гэрээ байгуулагдсанаар Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд барилга, угсралтын ажил нь санхүүжилтээс шалтгаалан зогссон байгаа төслүүдэд БНХАУ-ын Хөгжлийн банкнаас 15 хүртэл жилийн хугацаатай нэн хөнгөлөлттэй зээл олгох юм. /150 мянган айл-орон сууц /Үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан.<br>"Сервис центр" / Барилга, хот байгуулалтын яамнаас "Сервис центр" төслийг санаачлан салбарын инженерүүд, эрдэмтдийн санал, зөвлөгөөг тусган, төслийн ТЭЗҮ-ийг 2017-2018 онд боловсруулсан. / төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд эхний ээлжинд Чингэлтэй дүүргийн VII хорооны нутаг дэвсгэрт 221 нэгж талбарыг хамран, 14 га газарт төвлөрсөн зуух, инженерийн дэд бүтэц, цэвэрлэх байгууламж, авто зам, талбай, гэрэлтүүлэг, тохижилтын ажлыг 2019 онд ашиглалтад бүрэн оруулаад байна. Одоогийн байдлаар тус дүүргийн Хувьсгалчдын 11-15-р гудамжны 220 айл өрх инженерийн шугам сүлжээ, халаалт дулаан, цэвэр бохир усны шугаманд холбогдож, үйл ажиллагаа нь жигдрээд байгаа бөгөөд уг төсөл хэрэгжсэнээр 200 гаруй айлын янданг буулгаж чаджээ. Үүний үр дүнд тус бүс нутагт агаар, хөрсний бохирдол буурч, газрын үнэлгээ нэмэгдэн, иргэд өөрсдийн өмчлөлийн газартаа амины орон сууц, хаус барьж ая тухтай амьдрах нөхцөл бүрдсэн. Гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбож, агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор дараагийн ээлжинд Сүхбаатар дүүргийн XVIII хорооны нутаг дэвсгэрт уг төслийг хэрэгжүүлэхээр холбогдох ажлыг БХБЯ-наас эхлүүлээд байна. Гэр хорооллын иргэдийн дунд явуулсан судалгаагаар 80 гаруй хувь нь өмчлөл, эзэмшлийн газраа 2-3 өрөө байраар солихоос илүүтэйгээр тухай орчиндоо инженерийн шугам сүлжээ хангамжийг авч өөрсдийн амьдрах нөхцөлөө сайжруулан үр хүүхэддээ өвлүүлэн үлдээх хүсэлтэй байдаг гэсэн үр дүн гарсан байна. | 100% | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 9 | 16 | Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай<br>2019-01-29 | 3.. Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай. | Монгол туульс судлаач Батсүхийн Мөнхбадралыг мэдээллийн цаг арга хэмжээнд урьж оролцуулан эцэг өвгөдийн түүх соел, үндэсний үнэт зүйл, монгол ардын туульсийн дээж, туульс судлалын талаар лекц уншуулах арга хэмжээг зохион байгуулна. 2019 оны 6 дугаар сарын 01-нд Олон улсын хүүхдийн баяраар яамны албан хаагчдын хүүхдүүдийн дунд үлгэр, туульсын баатруудаар гар зургийн уралдаан зохион байгуулж хүүхэд тус бүрийг урамшуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | 12 | Хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах асуудлаар чиглэл өгөх тухай<br>2010-01-27<br>Дугаар 2 | 4.. Шинээр баригдаж буй хороолол, барилга, байгууламжуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд инженерийн бэлтгэл арга хэмжээг зайлшгүй тусгаж хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжлийн комисс цогцоор нь хүлээж авч байх журам тогтоох | Улаанбаатар хотын Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулагдсанаар шинээр баригдах хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд инженерийн бэлтгэл арга хэмжээг хотын өндөржилтийн нэгдсэн системтэй уялдуулан төлөвлөж тусгах, нэгдсэн ус зайлуулах сүлжээнд холбогдох боломжтой болох юм. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд 2012 оноос Улаанбаатар хотын 24 байршлын 29 хэсэгчилсэн талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд инженерийн бэлтгэл арга хэмжээг тусгуулан батлуулсан. Нийт 10060 айлын орон сууцыг барьж эхэлсэн бөгөөд тус хорооллуудад захиалагчийн хяналтыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу явуулан 5309 айлын орон сууц инженерийн бэлтгэл арга хэмжээтэй хийгдэж ашиглалтад орсон байна. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах ажлын даалгаварт инженерийн бэлтгэл арга хэмжээг цогцоор төлөвлөхөөр тусгаж боловсруулан батлуулж байгаа ба 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай, Өвөрхангай, Хэнтий, Завхан зэрэг 4 аймгийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гэрээ байгуулагдаж, 3 аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдаад байна. Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм"-ийн төсөлд "зураг төсөл боловсруулах шатанд тухайн орчны өндөржилт, инженерийн бэлтгэл арга хэмжээтэй уялдуулан төлөвлөх, мэргэжлийн байгууллагатай зөвшилцөх" гэсэн саналыг өгсөн бөгөөд дүрмийн 2 дугаар бүлгийн Зураг төсөл боловсруулах бэлтгэл ажлын 2.4.4-д инженерийн бэлтгэл ажилтай уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээ" гэж заалт оруулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 0% | |
| | 13 | | 14. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг батлах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүсийг бий болгох | Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүсийг бий болгох ажлын хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан.<br>Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБ-ын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 тоот тушаалаар байгуулсан.<br>-Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хийхэд шаардлагатай 783.8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБ-ын сайдын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/158 тоот тушаалаар байгуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 17 | Дугаар 2019_13 | 4.. Монгол баатарлаг туульсынхаа агуулга, ач холбогдлыг таньж ойлгох, дэмжин дэлгэрүүлэх, өв соёлоо хүндэтгэн дээдлэх, хадгалах, уламжлуулан хамгаалах үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг тбрийн ба төрийн бус байгууллага, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай. | Сар шинийн баяр буюу Цагаан сарын баярыг тохиолдуулан Барилгын салбараас төрөн гарсан Хөдөлмөрийн баатар, гавьяатууд, ямнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг "Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урьж, туульс хайлах арга хэмжээ болгон зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж төсөв батлуулсан болно. | 100% | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | |
| 10 | 18 | Хөтөлбөр батлах тухай /хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр/<br>2014-09-18<br>Дугаар 2014_298 | 3. Тухайн салбар, нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Тус яам Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрэм MNS BS 5906 стандартын дагуу холбогдох дүрэм, журмыг батлахаар ажиллаж байгаа бөгөөд нутаг дэвсгэрийнхээ хүрээнд барилгын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг БХБ-ын Сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хийсэн гэрээнд тусган үүрэг болгон ажиллаж байна. Барилгын хог хаягдлын журмыг дээрх стандартад нийцүүлэн Каритас Чех репаблик байгууллагатай хамтран боловсруулсан. Журмаар барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах,ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг зохицуулна. Хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой олон улсын байгууллагатай хамтран 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хогийн цэгүүд, дахин боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж журамд нэмэлтээр оруулах саналыг хэлэлцсэн. 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр төрийн болон ТББ-ын төлөөлөлтэй журамд нэмэлтээр оруулсан саналын тухай хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | 70% | |
| 11 | 19 | "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2016-11-30<br>Дугаар 2016_169 | 3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээлийн төлбөрт шаардагдах 30,286.0 (гучин тэрбум хоёр зуун наян зургаан) сая төгрөгийг хянан тооцсоны үндсэн дээр улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусган шийдвэрлэж, зээлийн хүүгийн төлбөрийг орон сууцны түрээсийн төлбөрөөс бүрдүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр нарт даалгасугай. | Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн Барилга, хот байгуулалтын сайдын урсгал зардлын багцад 5.0 тэрбум төгрөг тусгагдсан. Энэхүү санхүүжилтаар "ТОСК" ТӨХХК-ийн МУ-ын хөгжлийн банкинд төлөх өрийг барагдуулна. Ингэснээр энэхүү тогтоолд туссан үндсэн төлбөр болох 30.3 тэрбум төгрөгөөс 2019 он болон 2020 онуудад 10.0 тэрбум төгрөг төлөгдөнө. Үлдэгдэл санхүүжилтийг 2021 оны төсвийн төслийн саналд хүргүүлэхээр төлөвлөж байна.Зээлийн хүүгийн төлбөрийг ТОСК-ийн үндсэн орлого болох түрээсийн төлбөрийн орлогоос төлж байна. | 100% | |
| 12 | 20 | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах тухай<br>2017-01-04<br>Дугаар 2017_5 | 2. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, Үндэсний хороогоор хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгасугай. | Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг эхний байдлаар боловсруулсан "Дунд шатны тайлан 1"-ийн хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, салбарын мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачдыг хамруулан зохион байгуулж, холбогдох яам, газруудаас санал авч, төсөлд тусгаад байна. 2020 оны улсын төсөвт 2,8 тэрбум төгрөгийг тусган батлуулсан бөгөөд 2020 онд төслийн судалгааны ажлыг бүрэн хэрэгжүүлж дуусгана. Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 13 | 21 | Хөтөлбөр батлах тухай<br>2017-03-20<br>Дугаар 2017_98 | 3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо"-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Барилга, хот байгуулалтын сайдын 15 дугаар тушаалаар байгуулсан дэд хороог хуралдуулж хорооны зүгээс 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан. Энэ ажлын хүрээнд 17 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс 2019 оны хагас жилийн байдлаар 5 төсөл 100 биелсэн 8 төсөл хуваарийн дагуу хэрэгжиж байгаа бол 4 төсөл арга хэмжээ удаашралтай байна. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд УБ хотын төвлөрлийг сааруулах, томоохон суурин газруудын цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, иргэдийг орон сууцжуулах, инженерийн шугам сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлууд цогц байдлаар үе шаттай хийгдэнэ. Нийт 12 аймагт Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл болон Польш Улсын Засгийн газрын нөхцөлт зээлээр цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажил хийж байна.<br>Тайланг эцсийн байдлаар нэгтгэж, хуваарийн дагуу 2020 оны 1 дүгээр сард Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлнэ.<br>Мөн АХБ-ны Зүүн азийн газрын Байгаль орчин, Байгалийн нөөц, Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн дарга Omar Shariff B. Belisario-тай 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр, 9 сарын 6-ны өдрүүдэд уулзаж "Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах" төслийн 2 дугаар үе шатны бодлогын матрицад санал тусгуулсан бөгөөд Гэрээний саналтай танилцаж 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01/4460 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 22 | Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2017-03-29<br>Дугаар 2017_105 | 3. Засгийн газрын 2010 оны 140 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Тусгай хэрэгцээний газрын хилийн зааг”-ийн 7-д заасан “Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Хөшигийн хөндий (Олон улсын нисэх онгоцны буудал)-ын тусгай хэрэгцээний газартай давхацсан холбогдох хууль тогтоомж зөрчиж газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон болон газар эзэмших талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, давхцалыг арилгах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт тус тус даалгасугай. | Энэхүү ажилтай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/25 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгээс Засгийн газрын 2010 оны 140, 2016 оны 154 дүгээр тогтоолоор улсын тусгай хэрэгцээний газрын байршлыг тодорхойлж, 126 нэгж талбарын иргэн, аж ахуйн нэгжүүдийн газар давхцалтай байгааг тогтоож дүгнэлт гаргасан. Үүнтэй холбогдуулан ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 03/451 тоот, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгч “Гови травел” ХХК-д 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03/576, Төв аймгийн засаг дарга Ж.Батжаргал, Төв аймгийн Сэргэлэн сумын засаг дарга Э.Энхбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/736 тоот албан бичгийг тус тус хүргүүлж, чиглэл өгсний дагуу давхцалыг арилгаж газрыг БХБЯ-ны нэр дээр шилжүүлж, тусгай хэрэгцээний зориулалтаар гэрчилгээ авсан. Төв аймгаас 22 аж ахуйн нэгжийг хэвээр үлдээх хүсэлт ирүүлсэн тул батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу зориулалтыг өөрчлөн газар олгох шийдвэрийг гаргаад байна. | 100% | | |
| | 23 | | 5. Засгийн газрын 2012 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд тодотгол хийж, шинэ хот байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгасугай. | Засгийн газрын 2019 оны “Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. | 100% | | |
| 15 | 24 | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2017-11-15<br>Дугаар 2017_311 | 2.. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийг батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу барьж байгуулах асуудлыг шуурхай зохион байгуулан барилгын ажлыг 2018 оны II улиралд багтаан эхлүүлэх талаар бүх талын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан болон холбогдох сайд нарт даалгасугай. | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг эхлүүлж, 17,6 га талбайд баригдах шинэ цэвэрлэх байгууламжийн зураг төслийг Шанхайн зураг төслийн хүрээлэнд боловсруулж, 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ЭЗ-5/2019 тоот ерөнхий дүгнэлтээр магадлал хийлгэн баталгаажуулсан. Цахилгаан хангамжийн 45/2019, дулаан хангамжийн 145с/2019/87, холбоо дохиоллын ТН-В546/2019 тоот техникийн нөхцөлүүдийн сунгалт хийгдсэн. Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэн батлуулсан.<br>Цэвэрлэх байгууламжийн барилгын ажилд хэрэглэгдэх 120м3/цаг хүчин чадалтай бетон зуурмагийн 2 узелийг угсарч, БМҮ-БЭ-376/2019 тоот технологийн зааврыг батлуулсан. Узелийн машин механизм, тоног төхөөрөмжүүдийг шалгаж, МХЕГ-ын №18000000104 тоот аюулгүй ажиллагааны гэрчилгээгээр баталгаажуулсан.<br>Барилга байгууламжийн ажил эхлүүлэх 01/2019 тоот зөвшөөрөл авсан.<br>Зөвшөөрлийн дагуу төслийн барилга угсралтын талбайн бэлтгэл ажлыг хангаж түр ажилчдын байр, хашаа, цамхагт краныг байршуулан, биологи цэвэрлэгээний байгууламжийн суурийн газар шорооны ажил, бетон зуурмагын узель угсрах, байгууламжийн суурийн ул бетон цутгах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Төслийн нийт төсөвт өртөг 262,7 сая.ам.доллар.<br>Төв цэвэрлэх байгууламжийн лагийг үнэргүйжүүлэх, боловсруулах зорилгоор Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.1.20 дахь заалтад “Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” арга хэмжээг 2018-2020 онуудад 35,0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгагдан батлагдаж, энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.<br>Үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн “Ногоон сууц” ТББ, “Ногоон титэм” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээг, Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоолыг үндэслэн “Хийрэв” ХХК, “Ховд тул” ХХК, “Эко тайхи” ХХК-тай ажил гүйцэтгэх шууд гэрээг, лаг усгүйжүүлэх байгууламж барих түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй нээлттэй тендер шалгаруулалтаар "Ай вай и зэт групп" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулан, ажиллуулсан. | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 25 | | 5.. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барихтай холбогдуулан ариутгах татуургын байгууламжид нийлүүлэх хаягдал усны бохирдлыг бууруулж, стандартын шаардлагыг хангуулах зорилгоор ус бохирдуулсны төлбөрийн тухай болон бусад шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, хаягдал усыг дахин ашиглах талаар судалж санал боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарт тус тус даалгасугай | Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллан хуулийн төсөл 2019 оны 5 дугаар сард УИХ-аар батлагдсан. Хуулийг дагалдан батлагдах Ус бохирдуулсаны төлбөрийн хэмжээ тогтоох журмын төсөлд 2019 оны 06-р сарын 05-нд 01/2114 тоот албан бичгээр санал хүргүүлсэн бөгөөд санал туссан хэлбэрээр батлагдсан. Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүст хяналт тавих байцаагчтай байхаар Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулан 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр УИХ-аар батлуулсан. Энэ хуулийн төсөлд хаягдал усны асуудлыг шинээр тусгахаар үзэл баримтлалыг батлуулсан.<br>Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох үнэлгээ судлагааг хийсэн бөгөөд үзэл баримтлалын төслийг ХЗДХСайдаар 2019 оны 5-р сард батлуулан, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 16 | 26 | "Гурван тулгуурт хөгжлийн бодлого" батлах тухай<br>2018-02-06<br>Дугаар 2018_19 | 3.. "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-д тусгасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, бодлогын хэрэгжилтийг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийн явцыг нэгтгэн жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт тус тус даалгасугай. | "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-д туссан Барилга, хот байгуулалтын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх 5 зорилтын 17 төсөл, арга хэмжээ туссан. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан тайланг ЗГ-т хүргүүлэхээр Сайдын зөвлөлийн хурлаар 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэв.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |
| | 27 | | 1.2. гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулахад шаардлагатай нийгмийн болон инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг бий болгож, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжийн "Дэд бүтцийн төв" төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг татан оролцуулах замаар нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг эрчимжүүлэх, агаар, хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нийгмийн болон инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг бий болгох, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжийн "Дэд бүтцийн төв" төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх зорилгоор эхний ээлжинд БНХАУ-ын 700.0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийн ажлын жагсаалт /2020-2021/-д орох төсөл арга хэмжээг эрэмблэн жагсаалтыг шинэчлэн БХБЯ-ны ТНБД-аар 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр батлуулсан бөгөөд уг төсөл арга хэмжээний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр төслийн маягтын дагуу боловсруулан Сангийн яаманд болон МУ-д суугаа БНХАУ-ын Элчин сайдын яаманд 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр албан бичгээр уламжилсан. Мөн төслийн хураангүй танилцуулгыг холбогдох загвар маягтын дагуу бэлтгэж 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Сангийн яаманд болон МУ-д суугаа БНХАУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлээд байна."Сервис центр" / Барилга, хот байгуулалтын яамнаас "Сервис центр" төслийг санаачлан салбарын инженерүүд, эрдэмтдийн санал, зөвлөгөөг тусган, төслийн ТЭЗҮ-ийг 2017-2018 онд боловсруулсан. / төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд эхний ээлжинд Чингэлтэй дүүргийн VII хорооны нутаг дэвсгэрт 221 нэгж талбарыг хамран, 14 га газарт төвлөрсөн зуух, инженерийн дэд бүтэц, цэвэрлэх байгууламж, авто зам, талбай, гэрэлтүүлэг, тохижилтын ажлыг 2019 онд ашиглалтад бүрэн оруулаад байна. Одоогийн байдлаар 220 айл өрх инженерийн шугам сүлжээ, халаалт дулаан, цэвэр бохир усны шугаманд холбогдож, үйл ажиллагаа нь жигдрээд байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | 28 | Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2018-02-06<br>Дугаар 2018_43 | 1.5. эрчим хүчний хэмнэлттэй ахуйн цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах иргэдэд зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх асуудлыг судалж, саналаа 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт, амины орон сууцны байшин, гэрийн дулааны алдагдлыг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх санал, санаачилгыг дэмжиж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор баталсан “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-д эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд ипотекийн зээл олгох асуудлыг тусган шийдвэрлүүлсэн. . "Барилгын салбар дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ" төслийн хүрээнд барилгын дулаан алдагдлыг бууруулах, дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж суурилуулах загвар төслүүдийг хэрэгжүүлсэн. Улаанбаатар хотын Найдамдал, Буянт-Ухаа болон Шинэ Яармагийн нийт 12 дэд станцуудыг түгээх сүлжээний ухаалаг төхөөрөмж, тоолуурын нэгдсэн системд шинээр холбосон. Мөн барилгын салбарт НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр "Барилгын салбар дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ" төслийн хүрээнд “Барилгын дулааны хамгаалалт /БНбД 23-02-09/”-ын нормыг шинэчлэн боловсруулсан бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.<br>Олон Улсын хүлэмжийн хийг бууруулах сан /NAMA/-гийн нэгдүгээр шатны шалгаруулалтад Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэлийн төсөл шалгарч тус сангаас 18 сая еврогийн буцалтгүй тусламж авахаар шалгарч хоёр дахь шатны зөвлөлдөх уулзалт хийгдэж байна<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| | 29 | | 1.10. Улаанбаатар хотын дагуул хот, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт, дагуул хот, дэд төв, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүсийг бий болгох ажлын хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан.<br>Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 тоот тушаалаар байгуулсан.<br>-Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хийхэд шаардлагатай 783.8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/158 дугаар тушаалаар байгуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |
| | 30 | | 1.11. гэр хорооллын суурьшлын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийн дэд төвүүд барьж байгуулахтай холбогдуулан стандарт боловсруулж батлуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | Гэр хорооллын суурьшлын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжтай дэд төвүүд барьж байгуулахтай холбогдуулан стандартын төслийг “Монголын Ногоон хотын хөгжил судалгааны хүрээлэн”-гээс боловсруулж байна. Санхүүжилтийг "Цэвэр агаар сан"-аар дамжуулан Дэлхийн банкнаас шийдвэрлүүлсэн. Уг стандартын төслийн эцсийн хувилбарыг 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн Стандарт хэмжил зүйн Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, саналыг авч тусган 2020 оны 1 дүгээр сард дахин хэлэлцүүлж батлуулахаар ажиллаж байна. | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 31 | | 1.15. аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяа нэгжтэй Засгийн газрын зарим агентлаг болон төрийн байгууллага, төрийн өмчит их, дээд сургуулиудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан.<br>Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад , бүсийн хүн амыг 2030 онд 1763.0 мян байхаар тооцож дагуул хот тосгодын хүн ам 171.5 мянга болж өсөхөөр тооцоолж Багануур /Оюутны/, Багахангай, Аэросити (шинэ хот) зэрэг дагуул хот, тосгодыг тодорхой чиглэлийн үйлдвэр, худалдаа үйлчилгээ дагнан хөгжүүлэхээр тусгасан. Үүний дагуу Багануур /оюутны/ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусган боловсруулан батлуулж, хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулахаар ажиллаж байна. Түүнчлэн Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох жишиг "ухаалаг" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Хот байгуулалтын тухай хуульд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлуулсан. Батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ хотын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэнээр 2040 он гэхэд нийт 40 мянган ажлын байр бий болж, 35 мянган оршин суугч бүхий шинэ хот байгуулагдана. | 70% | | |
| | 32 | | 1.17. иргэдийн орлогод нийцсэн хямд өртөгтэй орон сууц болон түрээсийн орон сууц барихад шаардагдах хөрөнгийг зориулалтын сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | Тус яам Засгийн газрын 2019 оны 6 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолыг батлуулснаар ТОСК ХХК-ийн санхүүжилтгүйн улмаас зогссон орон сууцнуудыг Хөгжлийн банкны санхүүжилтээр барьж дуусган Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон сууцыг барьж түрээсийн орон сууцны санг бүрдүүлсэн. "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ын төслийг боловсруулж 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын 138 дугаар тогтоолоор батлуулсанаар зах зээлд түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэнд өмчлүүлэхээр хэрэгжиж буй 3457 айлын орон сууц байгаагаас 2387 айлын орон сууцанд иргэдийг хамруулсан. БНСУ-ын Экспорт-Импорт банкны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /EDCF/-ийн Үнэлгээний ажлын хэсэг, Сангийн яам, "ТОСК" ТӨХХК-тай хамтран "Солонго 1, 2 орон сууцны хороолол барих" төслийн зээлийн гэрээнд тусгах "Хэлэлцээрийн тэмдэглэл"-ийг эцэслэн боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр албажуулан, талууд гарын үсэг зурж баталгаажуулсан. 2020 оны 1 дүгээр сард багтаан Зээлийн хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.<br>2019 оны 7 дугаар сард "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт БХБЯ-ын ТНбД, БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн албаны дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Тус ажлын хүрээнд "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн барилга угсралтын ажлын бэлтгэл хангах төлөвлөгөө /2019-2020/-н ТНбД-аар 2019 оны 7 дугаар сард батлуулсан. Төслийн барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Интеллект тауер" ХХК шалгаран ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 11 дүгээр сарын 01-нд зураг төслийг боловсруулан батлуулж, эх хувь материалыг хүлээлгэн өгсөн. Барилгын зураг төслийн дагуу барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах Тендерийн баримт бичгийг боловсруулах ажлыг Төсөл хэрэгжүүлэх нэгж хариуцан гүйцэтгэж байна. Барилгын ажил 2020 онд эхэлнэ. | 100% | | |
| 18 | 33 | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2018-03-14<br>Дугаар 2018_73 | 3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх, холбогдох үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт үүрэг болгосугай. | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Монгол ТВ, Ийгл ТВ-үүдэд ярилцлага өгч, цахим сүлжээгээр шторк бэлтгэн явуулсан мөн БХТ-тэй хамтран Барилгын мэдээлэл нэвтрүүлэг дугаар 1, 2-ийг бэлтгэн мэдээллийг ТВ болон БХТ-ийн гадна дэлгэцээр олон нийтэд танилцуулга хийсэн.<br>ТНБД-ын 2018 оны 11 сарын 27-ны өдрийн А/182 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх" арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | 34 | “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2018-03-27 Дугаар 2018_81 | 2.. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан дуусаагүй барилгыг барьж дуусгахад шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд, 2018 оны 10 дугаар сард багтаан ашиглалтад оруулан цаашид төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд тус тус даалгасугай. | Засгийн газрын “Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 81 дүгээр тогтоолоор МУ-ын Хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан 1542 айлын орон сууцны барилгыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэх талаар холбогдох яам, тамгын газар, байгууллагуудаас саналын авч, шинжилгээ хийсний дүнд дээрх орон сууцнуудыг аймаг, нийслэлийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 6 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ тогтоолоор Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон нутгийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн бүртгэн оруулах ажлыг зохион байгуулсан. | 100% | |
| 20 | 35 | Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2018-06-20 Дугаар 2018_182 | 3.. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг газрын төлбөрийн орлогоос зохих журмын дагуу жил бүрийн төсөвт тусган батлуулах, зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд үүрэг болгосугай. | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг газрын төлбөрийн орлогоос зохих журмын дагуу жил бүрийн төсөвт тусган батлуулах чиглэлээр Төсвийн тухай хуульд /2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан/ Аймаг нийслэлийн төсвийн татварын орлогод газрын төлбөрийн 60%, сум, дүүргийн төсвийн татварын орлогод газрын төлбөрийн 40 хувийг дээрх зориулалтаар зарцуулахаар тусган батлуулсан. | 100% | |
| 21 | 36 | Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-08-01 Дугаар 2018_232 | 4.. Улсын хилийн зурваст боомтын зориулалттай төмөр зам барих барилгын ажлын зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хилийн боомтын үндэсний зөвлөл (Х.Хүрэлбаатар)-д тус тус даалгасугай. | Хилийн зурваст боомтын зориулалттай төмөр зам барих барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг тус яаманд өнөөдрийг хүртэл ирүүлээгүй байна . | Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй | |
| 22 | 37 | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258 | 1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын зүгээс тус яаманд ирүүлсэн албан бичгийн мэдээ, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, албан хаагчдын цаг ашиглалт, ирцийн мэдээг 7 хоног тутамд гаргуулж хяналт тавьж байгаатай холбоотойгоор ажлын цагийн хоцрогдол арилж, өргөдөл, гомдол, албан бичиг хугацаандаа шийдвэрлэгдэж байна.<br>2019 оны жилийн эцсийн байдлаар сахилгын шийтгэлийг 1 албан хаагчид оногдуулсан байна. | 100% | |
| 23 | 38 | Үйл ажиллагааны төсвийг шинэчлэн батлах тухай 2018-09-05 Дугаар 2018_280 | 2.. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай. | Зохицуулах зөвлөлийн 2019 төсвийн орлогын гүйцэтгэл нь 94.0 хувь, зардлын гүйцэтгэл нь 95.2 хувьтай байна /жилийн эцсийн байдлаар/ Зардлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавин ажиллаж байна. | 100% | |
| 24 | 39 | Дүрэм шинэчлэн батлах тухай 2018-10-24 Дугаар 2018_317 | 4.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | ЗГ-ын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулахаар 2019 оны 07/3070 тоот албан бичгээр холбогдох чиглэлийг өгч ажиллаж байна. | 100% | |
| 25 | 40 | Журам шинэчлэн батлах тухай 2018-10-24 Дугаар 2018_319 | 2.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд үүрэг болгосугай. | “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэл журам”-ын хэрэгжилтийг хангуулан ажиллахаар “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын боловсруулсан бүртгэлийн маягт, бүртгэлийн гэрчилгээ, гэрээний загваруудыг хянаж, Сайдын зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгээд байна. | 100% | |
| 26 | 41 | “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай 2018-10-31 Дугаар 2018_328 | 3.. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, компанийн өр, авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) нарт тус тус даалгасугай. | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны 23 дугаар тогтоолоор “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаардлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг баталсан. Уг компаний үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн Барилга, хот байгуулалтын сайдын урсгал зардлын багцад 5.0 тэрбум төгрөг тусгагдсан. Энэхүү санхүүжилтаар “ТОСК” ТӨХХК-ийн МУХБ-д төлөх өрийг барагдуулна. Ингэснээр энэхүү тогтоолд туссан үндсэн төлбөр болох 30.3 тэрбум төгрөгөөс 2019 он болон 2020 онуудад 10.0 тэрбум төгрөг төлөгдөнө. Үлдэгдэл санхүүжилтийг 2021 оны төсвийн төслийн саналд хүргүүлэхээр төлөвлөж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 27 | 42 | 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай<br>2019-01-16<br>Дугаар 2019_23 | 3. Хавсралтаар төлөвлөгөөг оруулав.. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.<br><br>Жич: Хавсралтаар оруулсан "ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана. | Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан яамны дотоод бүтцийн нэгж, харьяа газар, байгууллагуудад тараан хэрэгжилтийг хяналтад авч үнэлэн тайланг улирал бүр тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д байршуулан, баталгаажуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |
| 28 | 43 | Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай<br>2019-01-16<br>Дугаар 2019_29 | 2.. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан нийслэлийн хилийн цэст өөрчлөлт оруулах, шинэ хот /Аэросити/-ыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлаар холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх талаар шуурхай арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга (Ж.Батбаясгалан) нарт даалгасугай. | Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/ болон Төвийн тулгуур төв Төв аймгийн Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлагдсантай холбогдуулан нийслэлийн хилийн цэст өөрчлөлт оруулах, шинэ хот /Аэросити/-ыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн бий болох шинэ хотын судалгааг хийх зорилгоор БНСУ-ын Үндэсний хөгжлийн институттэй хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, БНСУ-ын талаас судалгааны ажлын санхүүжилтийг техник туслалцаагаар шийдвэрлэсэн.Санамж бичгийн дагуу шинэ хотын судалгаа болон чөлөөт бүс байгуулах, хотын бүтээн байгуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүй, бодлогын баримт бичиг болон батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн судалгааны ажлыг БНСУ-ын "Dohwa Engineering Co., Ltd" -аар гүйцэтгүүлсэн. Аэроситиг онгоцны буудлын байгууламжуудтай шууд холбох хэрэгтэй ба шинэ хотын төлөвлөгөөнд орсон орон сууцны хороолол нь Улаанбаатар хотын иргэдийн нягтаршлыг бууруулахад чухал нөлөө үзүүлэх боломжтой. Аэротрополисыг бий болгох зорилго нь мастер төлөвлөгөөний хүрээнд одоо байгаа дагуул хотууд болон нисэх онгоцны буудлын хот хоорондын уялдаа холбоог бий болгох явдал юм. Хэрэв эдийн засгийн олон чиг үүрэг бүхий Аэросити хот бий болбол Майдар, Зуунмод зэрэг дагуул хотууд эко хот, аялал жуулчлалын хот, аж үйлдвэрийн хот гэх мэт өөрсдийн чиг үүргийг тодорхойлох шаардлагатай ба Шинэ Аэросити хот нь өөрийн чиг үүрэгтэй өнгө аястай хот болох юм.Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас, Майдар хот төслийн иж бүрэн үнэлгээг хийлгэх 167 сая төгрөгийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. | 100% | |
| | 44 | | 3.. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2016 оны 174 дүгээр тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга (Ж.Батбаясгалан) нарт даалгасугай. | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" барим бичгийн хэрэгжилтийн байдал, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний УБ бүс нутаг, хот орчмын судалгаа"-ны ажил, "Улаанбаатар хотын 2040 он хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци"-ийг архитектурын мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар нээлттэй хэлэлцүүлсэн. Хурлаас өгсөн саналыг тусган НИТХТэргүүлэгчдэд 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр танилцуулсан. Хуралдаанаас НИТХ-аар хэлэлцүүлэх, мөн намын бүлгүүдээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэний дагуу НИТХ-ын дэргэдэх намын бүлгүүдийн хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр, НЗД-ын дэргэдэх "Аз жаргалын хороо"-ны хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, НИТХурлаар 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр тус тус хэлэлцүүлж НИТХ-ын гишүүдээс санал авсан. Хуралдаанаас НИТХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан санал өгөх ажил зохион байгуулагдаж НИТХ-аар 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хэлэлцүүлж 28/26 дугаар тогтоолоор дэмжигдсэн.<br>"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" баримт бичгийн хэрэгжилтийн байдал, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний УБ бүс нутаг, хот орчмын судалгаа"-ны ажил, Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх  ерөнхий төлөвлөгөөг  боловсруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ажлын хүрээнд БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-аар 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцүүлж, гишүүдээс гарсан саналуудыг тусган БХБ-ын сайдын зөвлөлийн 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж ЗГ-т хүргүүлэхээр шийдвэрлэсний дагуу саналыг нэгтгэн бэлтгээд байна. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 45 | | 4.. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан шинэ хот /Аэросити/-ын инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, эх үүсвэрийг барьж байгуулахад шаардагдах зардлыг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, нийслэлийн Засаг дарга (Ж.Батбаясгалан) нарт үүрэг болгосугай. | Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБ-ын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 тоот тушаалаар байгуулсан.<br>-Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хийхэд шаардлагатай 783.8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБ-ын сайдын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/158 тоот тушаалаар байгуулсан. | 100% | | |
| 29 | 46 | Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай<br>2019-01-16<br>Дугаар 2019_30 | 2.. Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж 2019 оны III улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд оруулан шийдвэрлүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгасугай. | Хот байгуулалтын тухай хуулийн 12.7-д “Орон нутгийн зэрэглэлтэй хотын захирагч нь хотын тогтвортой хөгжлийн бодлогын чиглэл, батлагдсан төлөвлөгөөний дагуу хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 жил тутамд боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.” гэж заасны дагуу мөн хуулийн 11.1.6-д “Хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь тухайн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулсан зураг төслийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг тооцож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлсон байх бөгөөд холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу иж бүрнээр нь тооцон төлөвлөнө гэсэн байдаг.<br>Гэвч орон нутагт хөрөнгө мөнгө нь төсөвт суудаггүй, улс төрийн шалтгаантай /хотын захирагч, ИТХ-ын ойлголцол/, мөн хүний нөөцийн чадамжаас шалтгаалж хэрэгжих боломжгүй төсөв мөнгөгүй арга хэмжээг төлөвлөх сонирхолгүй байна. Энэ байдлаас улбаалж хот, бүс нутаг хөгжүүлэх асуудал байнга гацдаг.<br>Энэхүү нөхцөл байдлыг харгалзан үзэж олон жил хэрэгжихэд хүндрэлтэй явж ирсэн арга хэмжээний хэрэгжих боломжийг бүрдүүлэхээр холбогдох хууль эрх зүйн орчныг судлан шинжилж салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д өргөн бариад байна.<br>Дээрх арга хэмжээний тухайд төсвийн жил эхэлсний дараа уг тогтоол батлагдсаны улмаас энэ жил хэрэгжүүлэх боломжгүй болсон. Харин ирэх жилээс /2020 онд/ хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусган хэрэгжүүлэхээр гэрээний төсөлд санал өгөөд байна. | 70% | | |
| 30 | 47 | “Майдар хот төсөл”-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2019-01-16<br>Дугаар 2019_32 | 1.. “Майдар хот төсөл”-ийг “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын хүрээнд судалж, эрх бүхий этгээдээр хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийлгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад тус тус даалгасугай. | Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардлагатай 783,8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 390 дүгээр тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн.Майдар хот төслийн хот байгуулатын иж бүрэн үнэлгээ боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны А/158 дугаар тушаалаар байгуулсан. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | 48 | 2019 оныг "Эх орончи худалдан авалтын жил" болгох тухай<br>2019-01-30<br>Дугаар 2019_59 | 3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | Эх орончи худалдан авалтын жил болгон зарласантай холбогдуулан эх орончи худалдан авалтыг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ТНБД-ын 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлав. "Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөл"-ийн үйл ажиллагааны хүрээнд батлагдсан 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийн тайланг Үндэсний хөгжлийн газарт 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 04/3316 хүргүүлсэн. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт"-ын хавсралтыг шинэчилэхэд 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 01/365 тоотоор санал хүргүүлж батлуулсан. Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолыг шинэчилэхэд барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг оруулах талаар санал боловсруулж, Сангийн яаманд 2019 оны 3 дугаар сар 12-ны өдрийн 02/822 тоот, 2019 оны 3 дугаар сар 22-ний өдрийн 01/1071 тоотоор хүргүүлсэн. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд Өмнөговь, Дорноговь, Архангай аймгуудын төв цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлыг гүйцэтгэж буй компаниудын дотоодын зах зээлээс худалдан авсан болон худалдан авах 5,285,010,702 /таван тэрбум хоёр зуун наян таван сая арван мянга долоон ззуун хоёр/ төгрөгийн бараа ажил, үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлүүлэх хүсэлтийг 03/2375, 03/2109, 03/2336 тоот албан бичгүүдээр Сангийн сайдад хүргүүлсэн. БХБЯ-аар дамжуулан хэрэгжүүлэх 42 төсөл,арга хэмжээний ХАА-г зохион байгуулахад дотоодын давуу эрх тооцохоор зарласнаас 17 компани хүсэлтээ ирүүлсэн байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | | |
| 32 | 49 | Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлах тухай<br>2019-03-21<br>Дугаар 2019_106 | 2.. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлагдсантай холбогдуулан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг шинэчлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэгдсэн барилгын салбарын техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай. | Үндэсний стандартын шинжлэх ухаан техникийн түвшинд хийсэн улсын үзлэгийн дүн болон шинэчлэн батлагдсан Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоонд үндэслэн салбарын дараах техникийн зохицуулалтуудыг боловсруулахаар Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ТНбД-аар батлуулсан. Үүнд: 1. Барилга, байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт 2. Барилгын материал бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалт 3. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт; Техникийн зохицуулалтуудыг боловсруулахад 300 сая төгрөг төсөвлөж, СХЗГ-ын даргын 2018 оны А/313 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Техникийн заавар боловсруулах заавар"-ын дагуу дараах боловсруулалтын ажлыг хангаж ажиллаж байна. Үүнд: - "Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төслийг Техникийн зохицуулалт боловсруулах үе шатуудын дагуу боловсруулан техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхээр бэлтгэж байна. Техникийн зохицуулалтын төсөлд Я.Дүйнхэржав, Б.Батбаатар зэрэг МУ-ын зөвлөх инженерүүдээр редакц шүүмж хийлгэн, МХЕГ, ОБЕГ, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар, ШУТИС, Барилга архитектур корпораци, Барилгын зураг төсөл зохиогчдын холбоо, Монголын барилгын инженерүүдийн холбоо, Монголын Архитекторуудын эвлэлд санал авахаар хүргүүлсэн. Дээрхи төрийн болон мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусган холбогдох баримт бичгийн боловсруулалтыг хангаж дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.<br>"Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах мөн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, ашиглалт болон буулгалттай холбоотой барилгын үйл ажиллагааг зохицуулахаар техникийн даалгаврыг боловсруулж 2019.11.28-ны 24/2019 тоотоор батлуулсан. | 70% | | |
| 33 | 50 | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай<br>2019-03-21<br>Дугаар 2019_111 | 2.. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч | Барилга, хот байгуулалтын Сайдын зөвлөлийн гишүүнээр Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн Б.Чулуундолгорыг сонгон ажиллуулж байна. Яамны ХШҮДАГ, ТЗУГ-ын хуулийн хэлтэст хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг тус тус ажиллуулж Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 51 | Журам батлах тухай<br>2019-04-10<br>Дугаар 2019_138 | 3.. Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг холбогдох хууль тогтоомжид заасан эх үүсвэрээс бүрдүүлэх, нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.<br><br>4. Түрээсийн орон сууц өмчлөх өргөдлийн маягт болон гэрээний загварыг баталж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд үүрэг болгосугай. | Засгийн газрын “Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 81 дүгээр тогтоолоор МУ-ын Хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан 1542 айлын орон сууцны барилгыг түрээсийн орон сууцны санд шилжүүлэх талаар холбогдох яам, тамгын газар, байгууллагуудаас саналын авч, шинжилгээ хийсний дүнд дээрх орон сууцнуудыг аймаг, нийслэлийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 6 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ тогтоолоор Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын орон нутгийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн бүртгэн оруулах ажлыг зохион байгуулсан. Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журмын дагуу байгуулах гэрээний загвар төслийг боловсруулж аймгуудад хүргүүлсэн. | 100% | | |
| 35 | 52 | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай<br>2019-07-03<br>Дугаар 2017_276 | 3.. Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны Б/85 дугаар тушаалаар яамны бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаал, чиг үүргийг шинэчилэн баталсан.<br>“Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 07 дугаар сарын 03-ны өдрийн 277 дугаар тогтоол, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 1, 9 дүгээр хавсралтыг удирдлага болгон ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/100 дугаар тушаал болон холбогдох бусад тушаалаар яамны албан хаагчдыг ажил, албан тушаалд томилж, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг дээрх тогтоолын дагуу 2019 оны төсөвт багтаан шийдвэрлэсэн. 2020 оны төсвийн саналд яамны албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх асуудлыг тавьж батлуулсан бөгөөд 2020 оны 01 дүгээр сарны 01-ний өдрөөс мөрдөж эхлэнэ. | 100% | | |
| 36 | 53 | Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай<br>2019-07-03<br>Дугаар 2019_270 | 5.. Аймаг, нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын ус хангамж, ариутгах татуургын системд их болон урсгал засвар хийх, туршилт тохируулгын ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Орон сууц Нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилтөд бэлтгэх ажлын төлөвлөгөөг 2019 оны 05 дугаар сарын 17-нд БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав.<br>Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн “Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын тогтоолын төсөлд 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдөр санал өгч, Орон сууц Нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилтөд бэлтгэх ажлын төлөвлөгөөний талаар мэдээлэл өгсөн.<br><br>Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 270 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, өвөлжилтийг хүндрэл багатай даван гарах иргэдийг ая тухтай байлгах, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулах зорилгоор “Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” сайдын 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 2019/26 тоот албан даалгаварыг батлуулж салбарын байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Мэдээг 7 хоног бүр Сайдын шуурхайд өвөлжилтийн мэдээг цаг тухай бүр тайлагнаж ажилласан. Хэрэгжилт хангалтгүй байгаа НАА байгууллагуудад тухай бүр үүрэг чиглэл өгч ажилласан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 37 | 54 | Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай<br>2019-07-03<br>Дугаар 2019_275 | 2.. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсантай холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 07 дугаар сарын 03-ны өдрийн 277 дугаар тогтоол, "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 1, 9 дүгээр хавсралтыг удирдлага болгон ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/100 дугаар тушаал болон холбогдох бусад тушаалаар яамны албан хаагчдыг ажил, албан тушаалд томилж, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг тогтоолын дагуу 2019 оны төсөвт багтаан шийдвэрлэсэн. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсантай холбоотой гарч болзошгүй нэмэлт зардлыг 2020 оны төсвийн төсөлд тооцон тусгуулж батлуулсан. 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн яамны зарим албан хаагчдын цалингийн шатлал ахиулах асуудлыг шийдвэрлүүлэхээр саналын төсөл боловсруулагдаж байна. | 100% | |
| 38 | 55 | Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай<br>2019-07-03<br>Дугаар 2019_277 | 2.. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтооход шаардагдах зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 07 дугаар сарын 03-ны өдрийн 277 дугаар тогтоол, "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 1, 9 дүгээр хавсралтыг удирдлага болгон ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/100 дугаар тушаал болон холбогдох бусад тушаалаар яамны албан хаагчдыг ажил, албан тушаалд томилж, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг дээрх тогтоолын дагуу 2019 оны төсөвт багтаан шийдвэрлэсэн. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсантай холбоотой гарч болзошгүй нэмэлт зардлыг 2020 оны төсвийн төсөлд тооцон тусгуулж батлуулсан. 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн яамны зарим албан хаагчдын цалингийн шатлал ахиулах асуудлыг шийдвэрлүүлэхээр саналын төсөл боловсруулагдаж байна. | 100% | |
| 39 | 56 | Чингис хааны музей байгуулах тухай<br>2019-07-03<br>Дугаар 2019_280 | 3.. Чингис хааны музейн ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, музейн барилгыг барихад дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарт тус тус даалгасугай. | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас "Чингис хаан музей"-н зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын төсөлд санал авахаар ирүүлсэний дагуу, төслийг судлан үзэж 2019 оны 10 дугаар сарын 14-ны 01/3866 тоот албан бичгээр төсөлд тусгуулах саналыг хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд Ё.Баатарбилэг, Нийслэлийн засаг дарга бөгөөд хотын захирагч С.Амарсайхан нар "Чингис хаан музей"-н ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаварыг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 2019/34, 2019/05, ЗТД-2019/03 дугаараар хамтран баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 40 | 57 | "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох журам" батлах тухай<br>2019-08-14<br>Дугаар 2019_316 | 3.. Энэ тогтоолын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт тус тус даалгасугай. | БОАЖ-ын сайдын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг дагалдан гарах захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж дараах захиргааны хэм хэмжээний актуудыг боловсруулан батлуулаад байна. Үүнд:<br>Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам;<br>Хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээний загвар;<br>"Хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрлийн бичгийн загвар"-ыг БОАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/719/189 тоот тушаалаар;<br>"Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай" БОАЖ-ын сайд, БХБ-ын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/816/218 тоот тушаалаар тус тус батлуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 41 | 58 | Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай<br>2019-08-14<br>Дугаар 2019_319 | 2.. Хилийн заагийг баталсантай холбогдуулан хилийн заагийн мэдээллийг холбогдох мэдээллийн санд бүртгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд, хамгаалалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нарт тус тус даалгасугай. | Газрын кадастрын мэдээллийн санд Төрийн өмчийн газрын бүртгэлийн давхаргыг үүсгэж, бүртгэлийн системийг хийж гүйцэтгэсэн.<br>Одоогоор нийслэлийн Газар зохион байгуулалтын алба уг мэдээллийн санг хөтөлж байна.<br>Хилийн цэсийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэх зорилгоор 1:25000 масштабтай байр зүйн зургийг 06 сарын 04-ны 10 Gb-ийн файлыг Архив, мэдээллийн төвөөс авч, Дундговь аймгийн нийт сумдын эргэлтийн цэгийн мэдээллийг 06 дугаар сарын 10-аас 28-ны өдрүүдэд боловсруулсан. Тус ажлын тайланг боловсруулж ажлын таарцыг шалгах, хээрийн хэмжилт тодруулалтын ажлыг 12 дугаар сарын 03-аас 05 -ны өдрүүдэд Дундговь аймгийн Сайнцагаан суманд газар дээр нь тулгах шалгах ажлыг гүйцэтгэсэн. Нийт 11 цэгээс 9 цэг нарийвчлал өндөртэй таарсан.<br>Улсын хэмжээний хилийн цэсийн маргааны судалгаар авахаар 2019 оны 1/2481 тоот албан бичгээр 21 аймагт хүргүүлсэн. Тус бичгийн хариуг орон нутгаас загвар хүснэгтийн дагуу хүлээн авч Улсын хэмжээнд нэгтгэн даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан. | 100% | |
| 42 | 59 | Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрын байршил, хэмжээг тогтоох тухай<br>2019-08-14<br>Дугаар 2019_323 | 2.. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг тухай бүр Засгийн газраар шийдвэрлүүлж байхыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд үүрэг болгосугай. | Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт холбогдох хууль, журмын дагуу газар ашиглуулах гэрээ байгуулах, БОАЖЯ, Нийслэлийн ЗАА-нд гэрчилгээ олгохоор гэрээний төслийг боловсруулан санал авахаар хүргүүлээд байна. ХХААХҮЯ-аас холбогдох материал ирүүлэх нь хүлээгдэж байна. | 70% | |
| 43 | 60 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай<br>2019-08-28<br>Дугаар 2019_337 | 2.. Улсын тусгай хэрэгцээнд авсан газарт холбогдох хууль, журмын дагуу газар ашиглуулах гэрээ байгуулах, гэрчилгээ олгох, уг газрын эргэлтийн цэгийн солбицлыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т даалгасугай. | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам"-ын дагуу Улсын тусгай хэрэгцээнд авсан газруудыг Газрын кадастрын нэгдсэн системд бүртгэж, Улсын тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ олгох, хувийн хэрэг үүсгэх ажлыг хийсэн.<br>Үүнд:<br>-Засгийн газрын 2018 оны 378 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсаны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд;<br>-УИХ-ын 2013 оны 53 дугаар тогтоолоор Дотоодын цэргийн 05 дугаар ангийн байнгын байрлалын зорилгоор 6.29 га газрыг, Цагдаагийн ерөнхий газрын Сүүж уул дахь сургалт, дадлагын цогцолбор төвийн зорилгоор 797.74 га газрыг, Дотоодын цэргийн 811 дүгээр ангийн Буудлагын талбайн зорилгоор 924.08 га газрыг, Дотоодын цэргийн 05 дугаар ангийн Хугацаат цэргийн албан хаагчдын зуны байрны зорилгоор 58.93 га газрыг тус тус нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутагт, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн байнгын байрлалын зорилгоор 3.13 га газрыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутагт Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд.<br>-Улсын тусгай хэрэгцээний газрыг Кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулахтай холбоотойгоор Ланд менежер программд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийсэн. Энэхүү программыг ашиглан Хөшгийн хөндийн олон улсын онгоцны нисэх буудал, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын газрын мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. | 100% | |
| 44 | 61 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай<br>2019-09-18<br>Дугаар 2019_357 | 2.. Улсын тусгай хэрэгцээнд авсан газрын хил заагийн мэдээллийг газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэж, холбогдох журмын дагуу газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т даалгасугай. | "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих" газрыг улсын тусгай хэрэгцээнд авч хил заагийн мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, холбогдох журмын дагуу газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгов.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 45 | 62 | Хөрөнгө гаргах тухай<br>2019-10-30<br>Дугаар 2019_390 | 2.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт тус тус даалгасугай. | - Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 тоот тушаалаар байгуулсан.<br>-Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хийхэд шаардлагатай 783.8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/158 тоот тушаалаар байгуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 46 | 63 | Ажлын хэсэг байгуулах тухай “Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд тодотгол хийх<br>2017-07-03<br>Дугаар 2017_122 | 2.. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэрэгжилтийг дүгнэн асуудлыг цогцоор нь судалж, саналаа Ерөнхий сайдад тухай бүр танилцуулан чиглэл авч ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай. | Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБ-ын ТНБД-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 тоот тушаалаар байгуулсан. Засгийн газрын 2019 оны “Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан.<br>-Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хийхэд шаардлагатай 783.8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБ-ын ТНБД-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/158 тоот тушаалаар байгуулсан.Ерөнхий сайдад саналыг тухай бүр танилцуулж ажиллаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |
| 47 | 64 | Ажлын хэсэг байгуулах тухай “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих”<br>2017-12-06<br>Дугаар 2017_175 | 2.. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллан ажлын явцыг Монгол Улсын Ерөнхий сайдад тухай бүр танилцуулан чиглэл авч байхыг Ажлын хэсэг (Х.Баделхан)-т үүрэг болгосугай. | Шинэ цэвэрлэх байгууламжийн ажлын нарийвчилсан зураг төслийг Шанхайн зураг төслийн хүрээлэнд боловсруулж дуусгасныг орчуулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөж 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Барилгын хөгжлийн төвд экспертиз хийлгүүлээд байна.<br>Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэж Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар ерөнхий үнэлгээг хийлгэж баталгаажуулсан.<br>Төслийн барилга угсралтын талбайн бэлтгэл ажлыг хангаж түр ажилчдын байр, хашаа, цамхагт краны байршуулан, биологи цэвэрлэгээний байгууламжийн суурийн газар шорооны ажил, бетон зуурмагийн үзель угсрах, байгууламжийн суурийн ул бетон цутгах зэрэг ажлуудыг гүйцэтгээд байна. Холбогдох мэдээллийг цаг тухайд гарган өгч байгаа бөгөөд төсөлтэй холбогдуулан Засгийн газрын 2019 оны 337 тогтоол, 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр 11 дүгээр тэмдэглэлүүдийг гаргуулан ажиллаж байна.<br><br>Хавсралт : 5 файл | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 48 | 65 | Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2018-04-06<br>Дугаар 2018_68 | 1.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын гамшиг, гал түймэр, ослын аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулах, барилга байгууламжид тавигдах шаардлагыг газар дээр нь шалгаж, үнэлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарт, дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцох, хамаарах нутаг дэвсгэр, салбар, байгууллагын холбогдох чиглэлийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт; | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл" нь Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар ашиглалтын шаардлага хангахгүйг тогтоосон яаралтай буулгаж, шинээр барих барилга байгууламжийн жагсаалтыг гарган Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 206 дугаар тогтоолыг нууцын журмаар баталсан. Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 2019 оны төсөвт тусгасан эсэх болон гадаад, дотоодын хөнгөлөлттэй тусламж, зээлд хамруулах боломжтой талаарх хариуг тус яаманд ирүүлэхийг хүссэн нууц албан бичгийг 12 дугаар сарын 10-ны Н/77 тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн тогтоолын хавсралтад заасан нурах аюултай, осол гарах эрсдэлтэй нийтийн орон сууц, олон нийтийн барилга байгууламжийг буулган шинээр барих төслийг орон нутгийн төсөвт тусган, 2019 оноос эхлүүлэх, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах талаарх нууц албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2018 оны 11 дүгээр сарын 12-ны Н/67 тоотоор хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яамны улсын албанаас гамшиг, гал түймэр, ослын аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 77 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.<br>Монгол Улсын хэмжээнд 2018 онд хийсэн судалгаагаар нийт 459 орон сууц, 52 цэцэрлэг, 65 сургууль, 70 эмнэлэгийн барилга байгууламж газар хөдлөлтөд тэсвэргүй ашиглалтын шаардлага хангахгүй буулгаж шинээр барих шаардлагатай байна. Үүнээс 2019 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 75 орон сууцны барилга байгууламжийг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна. Мөн аймаг орон нутгийн хэмжээнд 6 орон сууц, 1 сургууль, 2 хичээлийн байр, 2 соёлын төв, 1 асрамжийн барилгыг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна. | 100% | |
| | 66 | | 1.2. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд өмчийн төрөл, хэлбэрийг үл харгалзан орон сууц, олон нийтийн барилга байгууламж, хүн ам олноор цугларах үзвэр, үйлчилгээний газар, галт тэрэг, нисэх онгоцны буудал, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжийн гамшиг, гал түймрийн үед ашиглах орц, гарцын төлөвлөлт, техникийн шаардлага, гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах зориулалт бүхий техник, тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт, бэлэн байдалд болон тэдгээр обьектод гал унтраах машин нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийг хүргэхэд шаардлагатай орон зай, гудамж, замын сүлжээ хүрэлцэж байгаа эсэхэд 2018 оны 5 дугаар сарын 1-ний дотор хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, дүнг мөн оны 5 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайдад даалгаж энэ талаар хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт; | Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан шалгалтын ажлын хэсэгт Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аас төлөөлөл оролцон Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд өмчийн төрөл, хэлбэрийг үл харгалзан орон сууц, олон нийтийн барилга байгууламж, хүн ам олноор цуглarах үзвэр, үйлчилгээний газар, галт тэрэг, нисэх онгоцны буудал, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжийн гамшиг, гал түймрийн үед ашиглах орц, гарцын төлөвлөлт, техникийн шаардлага, гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах зориулалт бүхий техник, тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт, бэлэн байдалд болон тэдгээр обьектод гал унтраах машин нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийг хүргэхэд шаардлагатай орон зай, гудамж, замын сүлжээ хүрэлцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтын дүнг өнгөрсөн онд Шадар сайдад танилцуулсны дагуу тус яам холбогдох арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд дараах норм, нормативын баримт бичгийг боловсруулах ажлууд хийгдсэн. Үүнд: 1. “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт” БНбД-н төслийг Монголын галын аюулгүйн инженер техникчдийн холбооноос боловсруулж ирүүлснийг хянаж байна. 2. “Барилга байгууламжийн галын аюулаас урьдчилан сэргийлэх барилгын дүрэм” БНбД-г Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/, Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 21-02-02/ дүрмүүдтэй уялдуулан боловсруулж 90%-тай явж байна. 3. “Объектын галын тархалтын хамгаалалт” БД-н төслийг боловсруулж байна. 4. Орон сууц олон нийтийн барилгын утаанаас хамгаалах систем БД-г боловсруулахаар зөвлөх үйлчилгээ авахаар тендер зарласан.Цаашид хоолбогдох норм дүрмийг шинэчлэх ажил хийгдээд явж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 67 | | 2.. Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулахтай холбогдуулан хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгч, хэрэгжилтийг хангуулах талаар шаардлагатай арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд болон холбогдох сайд нарт тус тус даалгасугай. | Уг ажлын хүрээнд хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгөх бүхий ажлын хэсгийг байгуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн 2020 оны норм, нормчлалын сангийн төлөвлөгөөнд барилгын салбарт хүчин төгөлдөр ашиглагдаж байгаа газар хөдлөлтийн норм дүрмэнд шинжилгээ хийх талаарх үйл ажиллагааг тусгасан.<br>Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан шалгалтын ажлын хэсэгтэй хамтран Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд өмчийн төрөл, хэлбэрийг үл харгалзан орон сууц, олон нийтийн барилга байгууламж, хүн ам олноор цугларах үзвэр, үйлчилгээний газар, галт тэрэг, нисэх онгоцны буудал, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжийн гамшиг, гал түймрийн үед ашиглах орц, гарцын төлөвлөлт, техникийн шаардлага, гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах зориулалт бүхий техник, тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт, бэлэн байдалд болон тэдгээр обьектод гал унтраах машин нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийг хүргэхэд шаардлагатай орон зай, гудамж, замын сүлжээ хүрэлцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтын дүнг өнгөрсөн онд Шадар сайдад танилцуулсны дагуу тус яам холбогдох арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна.<br>Дээрх арга хэмжээний үр дүнд 1. “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт” БНбД-н төслийг Монголын галын аюулгүйн инженер техникчдийн холбооноос боловсруулж ирүүлснийг хянаж байна. 2. “Барилга байгууламжийн галын аюулаас урьдчилан сэргийлэх барилгын дүрэм” БНбД-г Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/, Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 21-02-02/ дүрмүүдтэй уялдуулан боловсруулж 90%-тай явж байна. 3. “Объектын галын тархалтын хамгаалалт” БД-н төслийг боловсруулж байна. 4. Орон сууц олон нийтийн барилгын утаанаас хамгаалах систем БД-г боловсруулахаар зөвлөх үйлчилгээ авахаар тендер зарласан. | 100% | |
| 49 | 68 | Ажлын хэсэг байгуулах тухай<br>2019-07-04<br>Дугаар 2019_94 | 2.. Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн барих асуудлаарх саналаа 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай. | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн ХЭГ/2204 бичгээр ирүүлсэн Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/3001 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.<br>НЗД-ын Тамгын газраас 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 03/4516 дугаартай албан бичгээр “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-ийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын төсөлд санал авахаар ирүүлсэнийг судлаж 2019 оны 10 дугаар сарын 14-ны 03/3863 дугаартай албан бичгээр санал хүргүүлэв.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 50 | 69 | 2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар тэмдэглэл<br>2016-04-04<br>Дугаар 2016_20 | Х. . Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд уг хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран баталж, хуулийн төслийг боловсруулан зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нарт даалгав. | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХСайдтай хамтран баталсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 30, 31-ны өдөр ажлын хэсгийн хурлыг тус тус зохион байгуулсан. Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын дагуу хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог боловсруулсан. Хуулийн төслийг ГЗБГЗЗГ-ын даргын зөвлөлийн хурлаар 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцүүлээд байна. 2020 онд ЗГХ-аар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 51 | 70 | 2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл<br>2017-01-04<br>Дугаар 2017_1 | IY.2. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах ажлын хэсэг байгуулан ажиллаж, уг асуудлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулан чиглэл авахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгав. | БХБСайдын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 31 дүгээр тушаалаар "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл" боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Зөвлөх багийг байгуулан ажиллуулж байна. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын техникийн туслалцаагаар хэрэгжүүлэх "Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах төсөл"-ийн хүрээнд "Үндэсний хөгжлийн цогц бодлого", "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого", "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" зэрэг бодлогын баримт бичгүүдийг харилцан уялдаатай боловсруулах зорилгоор салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий "Төслийн хамтарсан зохицуулах хороо"-г Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 32 дугаар захирамжаар байгуулсан. Төслийн хүрээнд Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй, мал аж ахуй, Байгаль орчин, аялал жуулчлал, Хот ба дэд бүтэц,Нийгмийн салбар гэсэн 5 дэд ажлын хэсгийг БХБСайдын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 110 дугаар тушаалаар байгуулсан. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулахад шаардагдах 600 сая төгрөгийг 2019 онд, 2,8 тэрбум төгрөгийг 2020 оны Төсвийн тухай хуульд тус тус тусган батлуулсан.<br>Төслийн Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх багийн "Дунд шатны тайлан 1"-ийн хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан.<br><br>Хавсралт : 3 файл | 100% | |
| | 71 | | IV.4. . Хот, суурин газарт хүн амын хэт төвлөрөл бий болсон шалтгаан, нөхцөлийг тогтоох, түүнийг арилгах чиглэлээр шинэ суурьшил, дэд бүтцийг бий болгох, орон нутагт оруулах хөрөнгө оруулалт болон ажлын байр нэмэгдүүлэх, орон нутагт шилжин суурьших иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулж, дэмжлэг үзүүлэх, урамшуулах асуудлаар хөтөлбөр хэрэгжүүлэх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг харгалзан үзэх зэрэг Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг анхаарч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгав. | Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүсийг бий болгох ажлын хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан.<br>Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 602,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 тоот тушаалаар байгуулсан.<br>-Майдар хот төсөл хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил явуулах болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хийхэд шаардлагатай 783.8 сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулахад шаардлагатай 167,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2019 оны 390 тогтоолоор шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Майдар хот төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБЯ-ны ТНБД-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/158 тоот тушаалаар байгуулсан.<br>Мөн хууль эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчисэн найруулгын төслийг боловсруулах УИХ-д өргөн мэдүүлээд байна.Иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор 150 мянган айлын орон сууц хөтөлберийг ЗГ-ын 2019 оны 202 дугаар тогтоолыг батлуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |
| 52 | 72 | 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл<br>2017-09-13<br>Дугаар 2017_39 | XYI.2.. Монгол Улсын геодезийн эхлэл цэгийн барилга байгууламжийг барьж байгуулахдаа зэргэлдээ орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Заяын гэгээний хийдийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд аюул, хохирол учруулахаас сэргийлж, архитектур төлөвлөлтийн хувьд түүнтэй уялдуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Мөнхбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүү нарт тус тус даалгав. | Монгол Улсын геодезийн сүлжээний Эхлэл цэгийн төвийг Архангай аймгийн Эрдэнэбулган суманд суулгаж, тухайн цэгийн солбицлыг тодорхойлох хэмжилтийн ажлыг зохих хууль, тогтоож, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ хийн гүйцэтгүүлсэн. Уг ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 39 дүгээр хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллаж, тус аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт актаар хүлээлгэн өгсөн.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 53 | 73 | 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр 42 дугээр тэмдэглэл 2017-09-27 Дугаар 2017_42 | YIII.2.. Хог хаягдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих байршил болон газар олгох асуудлыг судалсны үндсэн дээр уг газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Оюунхорол, Барилга, хот байгуулалтын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Мөнхбаяр нарт даалгав. | Нийслэлийн Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 10 га, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Төв цэвэрлэх байгууламж"-ийн дэргэд 22 га газрыг аюултай хог хаягдал, лаг боловсруулах, булшлах, устгах байгууламж барих зориулалтаар тус тус улсын тусгай хэрэгцээнд авч Засгийн газрын 2019 оны 337 дугаар тогтоолоор батлуулсан. | 100% | |
| 54 | 74 | 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдөр 20 дугаар тэмдэглэл 2018-05-02 Дугаар 2018_20 | XXII.9. . "Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. БНЭУ-ын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан, явц, үр дүнгийн талаар танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноров нарт  тус тус даалгав. | Барилга, хот байгуулалтын яам нь "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн "Үйлдвэрийн хашаа барих, талбайн газар шорооны ажил"-ыг "Нутгийн зам групп" ХХК-тай Түлхүүр гардуулах нөхцөлтэй гүйцэтгэгчийн гэрээг 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 2018/246 тоотоор байгуулсан. Уг ажил гүйцэтгэх гэрээнд магадлалын нэгтгэсэн дүгнэлт гарсантай холбогдуулан гэрээний үнийн дүн өөрчлөгдсөн, гэрээний хугацаа дуусаж байгаатай холбогдуулан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2019/252 тоотоор гэрээг шинэчлэн байгуулсан. Энэ хүрээнд үйлдвэрийн хашаа барих, газар шороо болон ойн зурвас байгуулах ажлыг 2020 оны 10 дугаар сар хүртэл хийж гүйцэтгэхээр болсон бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 55 | 75 | 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2018-05-16 Дугаар 2018_21 | XXIX.2. 3. . Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, хэрэгцээт мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллагыг хангахад анхаарч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, хэрэгцээт мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллагыг хангаан ажиллалаа.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| | 76 | | XXIX.2. 4. . Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцон ажиллахыг төрийн байгууллагын удирдлагуудад даалгав. | Барилга, хот байгуулалтын сайдын 05 дугаартай албан даалгаврыг 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдөр батлаж, Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 03/3223 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /ГЗБГЗЗГ/, Төрийн орон сууцны корпораци /ТОСК/, Барилгын хөгжлийн төв /БХТ/-д хүргүүлж , биелүүлж ажиллах чиглэл, зөвлөмжийг өгч, хугацааны эцэст хэрэгжүүлсэн ажлыг заалт бүрээр гаргуулан тайланг нэгтгэж ЗГХЭГ-т хүргүүлсэн.Сайдын албан даалгавар нь нийт албан хаагчид болон харьяа байгууллагын хувьд дотоод журмын адил үйлчлэх тухай анхааруулсныг мөн тайлбарлан хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.<br>Дээрх үүрэг даалгаврыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хяналт тавин ажилласан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 56 | 77 | 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 23 дугаар тэмдэглэл 2018-05-30 Дугаар 2018_23 | XXIX.1. . Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 2018 оны I улиралд "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн арга хэмжээг тус яам төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 57 | 78 | 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 26 дугаар тэмдэглэл<br>2018-06-13<br>Дугаар 2018_26 | XIX.3. . Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор баталсан Төреөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>3.1. Төреөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь ирүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгов. | Барилгын салбарт төреөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг БХБ-ын Сайдын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны 67 дугаар тушаалаар баталсан. 2020 онд ХШҮ хийхээр яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж батлуулсан. | 100% | |
| | 79 | | 10.3. . Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (салбар төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай, хашаа)-ын хүрээнд хийгдэх ажлыг батлагдсан ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, төсвийн дагуу эхлүүлэхийг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт зөвшөөрч, уг дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг тухай бүр шуурхай шийдвэрлэж байхыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баярмагнай)-д даалгав. | Энэхүү ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Барилга, хот байгуулалтын яам нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай "Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах газрын тос боловсруулах үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийн хашаа, цөлжилтөөс сэргийлэх ойн зурвас байгуулах, ажлын зураг төсөл боловсруулах, барьж байгуулах ажлын ерөнхий гэрээ"-г 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан. Уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/140 тушаалаар байгуулж "Нутгийн зам групп" ХХК-тай 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 246 тоот дугаартай гэрээ байгуулсан.<br>Уг ажил гүйцэтгэх гэрээнд магадлалын нэгтгэсэн дүгнэлт гарсантай холбогдуулан гэрээний үнийн дүн өөрчлөгдсөн, гэрээний хугацаа дуусаж байгаатай холбогдуулан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2019/252 тоотоор гэрээг шинэчлэн байгуулсан. Үүний хүрээнд үйлдвэрийн хашаа барих, газар шороо болон ойн зурвас байгуулах ажлыг 2020 оны 10 дугаар сар хүртэл хийж гүйцэтгэхээр болсон бөгөөд гэрээт ажил хийгдэж эхлээд байна. | 100% | |
| | 80 | | XIX.4. . "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газарт хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах асуудлын талаар Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын захиалгаар барьж, төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг шийдвэрлэх тодорхой санал боловсруулан танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Ж.Хичээнгүй нарт даалгав. | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны 23 дугаар тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг баталсан. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн Барилга, хот байгуулалтын сайдын урсгал зардлын багцад 5.0 тэрбум төгрөг тусгагдсан. Энэхүү санхүүжилтаар "ТОСК" ТӨХХК-ийн МУХБ-д төлөх өрийг барагдуулна. Ингэснээр үндсэн төлбөр болох 30,3 тэрбум төгрөгөөс 2019 он болон 2020 онуудад 10,0 тэрбум төгрөг төлөгдөнө. Үлдэгдэл санхүүжилтийг 2021 оны төсийн төслийн саналд хүргүүлэхээр төлөвлөж байна. | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 58 | 81 | 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр 35 дугаар тэмдэглэл 2018-08-22 Дугаар 2018_35 | XIX.6. . Стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн сансрын өндөр нарийвчлал бүхий зураг цуглуулан мэдээллийн сан үүсгэх, мэдээлэлд үндэслэн тооцоо судалгаа, дүгнэлт хийх замаар уул уурхайн олборлолт явуулах талбайн хяналтын тогтолцоог бий болгох асуудлыг судлах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд; | Азербайджаны азерксмос байгууллагатай 2019 оны 11-р сард СПОТ-5 хиймэл дагуулын өндөр нарийвчлалын зураг хамтран ашиглах хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн дагуу УБ-Дарханы авто замын бүтээн байгуулалтын ажлыг хянах, төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцыг хянах, газар тариалангийн бүсэд тариалангийн ургацын татвар тооцоо гаргах, уул уурхайн олборлолтын тооцоо, талбайн хяналт, суурин газрын өөрчлөлтийг судлах /баригдаж буй барилгын явцын хяналт/ хийхээр 5 газрын байршлыг сонгож судалгааны обьект болгон 2020 онд судалгааны ажил хийхээр төлөвлөсөн. Танилцуулга бэлтгэн Сангийн сайд, Татварын ерөнхий газрын дарга нарт танилцуулсан ба Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын дарга, нарт танилцуулахаар бэлтгэж байна. Мөн УАБЗ-д 2019 оны 11 сарын 25-ны өдөр байр зүйн зургийн талаар танилцуулах үед сансрын зургийн хэрэглээний талаар танилцуулсан. 2020 онд сансрын зураг ашиглан газар шорооны ажлын хэмжээ гаргахад шаардлагатай програм хангамж худалдан авах, мэргэжилтнийг сургахаар төлөвлөсөн. Зардлыг ҮОЗӨДБ байгуулах хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлаас гаргахаар ГЗБГЗЗГ-ын төсөвт тусгаж батлуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | 70% | |
| 59 | 82 | 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2018-08-29 Дугаар 2018_36 | XIY.1. . Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон албан тушаалтанд хандаж иргэдээс 2018 оны эхний хагас жилд "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | Барилга, хот байгуулалтын яам, түүний харьяа байгууллагад 2019 оны жилийн эцсийн байдлаар иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан. 2019 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 4887 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг иргэдээс ирүүлсэн байна.Нийт өргөдөл гомдлын дийлэнх буюу 70.7 хувийг ипотекийн зээлэнд хамрагдах, орон сууцанд ороход дэмжлэг үзүүлэх, түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах хүсэлт ээлж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал жилийн эцэст 98.3%-ийн биелэлттэй байна.<br>Иргэдийн дунд хамгийн их хүлээлттэй байгаа орон сууцны асуудлыг шийдвэрлэх хүрээнд тус яам хэд хэдэн бодлогын баримт бичгүүдийг боловсруулж ажилласан. Үүнд: "Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам"-ыг Засгийн газрын 369 дүгээр тогтоолоор батлуулж, анх удаагаа ипотекийн зээлийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлж, Хөгжлийн банкны санхүүжилтээр орон нутагт 570 айл, нийслэлд 972 айл, нийт 1542 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэн өгсөн ба "Орон сууцны тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 46 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн бариад байна.<br>Хүн амыг орон сууцжуулах, эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаат ундны усаар хангах, бохир усыг цэвэршүүлэх, ахуйн хог хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох, инженерийн шугам сүлжээг өргөтгөх зэрэг иргэд рүү чиглэсэн, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх "Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.<br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 03/28 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 60 | 83 | 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 44 дүгээр тэмдэглэл 2018-10-24 Дугаар 2018_44 | XXYI.2.2. "Монцемент билдинг материалс" ХХК-ийн барилгын материалын үйлдвэр барих зориулалтаар импортоор оруулсан тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд; | "Монцемент билдинг материалс" ХХК-ийн барилгын материалын үйлдвэр барих зориулалтаар импортоор оруулсан тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судлан дэмжиж, Сангийн сайдад албан тоотоор уламжлав.<br><br>Хавсралт : 2 файл | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 61 | 84 | 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 2 дугаар тэмдэглэл<br>2019-01-09<br>Дугаар 2019_2 | XXIII.3. . -хот, суурин газрын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор хот байгуулалт, хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд тавигдах барилгажилт, орчны тохижилтын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн шаардлагуудыг хангуулах, мөрдүүлэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, шаардлагатай бол тусгай зохицуулалт, хязгаарлалт тогтоох асуудлыг судалж, саналаа Засгийн газарт танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд; | 2018 онд тус яамнаас хот, суурин газрын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор хот байгуулалт, хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд тавигдах барилгажилт, орчны тохижилтын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн шаардлагуудыг хангуулах, мөрдүүлэх зорилгоор Автозогсоолын тухай хуулийн төслийг боловсруулахаар холбогдох судалгаануудыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулж Сайдын зөвлөлийн хуралдаанд иж бүрнээр нь танилцуулсан боловч Хот байгуулалтын тухай хуулийн төсөлтэй нэгтгэх санал гаргасны дагуу Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд автозамын ачааллыг бууруулах зорилгоор хот байгуулалтын баримт бичигт зайлшгүй тусгаж байх шаардлагыг тусгасан. Хуулийн төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэнээр 55 дугаар тэмдэглэл гарч УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон. УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар ХЗДХЯ, СЯ руу албан бичиг хүргүүлээд байна.<br><br>Хавсралт : 4 файл | 100% | |
| 62 | 85 | 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 дугаар тэмдэглэл | I.. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:<br><br>1.Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны I улиралд багтаан олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах;<br><br>2.Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх;<br><br>3.Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх;<br><br>4.Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмыг зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байх; | Арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг ханган ажилласан. Тайланг хавсаргав<br><br>Хавсралт : 2 файл | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 86 | 2019-01-16<br>Дугаар 2019_3 | II.. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов:<br><br>1.1. төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;<br><br>1.2. төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн (мерит) болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах;<br><br>1.3. төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны хуульд заасан шаардлага хангаж байгаа албан тушаалтнуудыг зохих журмын дагуу томилох, шаардлага хангахгүй байгаа албан тушаалтнуудыг үүрэгт ажлаас чөлөөлж, дүнг 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор | Арга хэмжээ нэг бүрийг холбогдох газруудад хуваарилан биелэлтэд хяналт тавьж ажилласан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% | | |
| 63 | 87 | 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр 11 дугаар тэмдэглэл<br>2019-03-21<br>Дугаар 2019_11 | XXIII.2. . БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр барих Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламжид мөрдөх стандарт, цаашид авах арга хэмжээний талаар Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих" төслийн хүрээнд барьж, ашиглалтад оруулах цэвэрлэх байгууламжид мөрдөх стандартын үзүүлэлтийг БНХАУ-ын "А" ангиллын GB 18918-2002 стандартаар тооцох талаар холбогдох гэрээнд өөрчлөлт оруулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд, төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээ хийж, гэрээ байгуулах талаар шуурхай арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт тус тус даалгав. | 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдөр БНХАУ-ын "А" ангиллын GB 18918-2002 стандартаар тооцох талаар нэмэлт өөрчлөлтийг оруулж гэрээний үнийн дүнг 262,710,119.53 ам.доллароор хоёр тал харилцан тохиролцож гэрээг баталсан. | 100% | | |
| | 88 | | XXIII.14. . 4. Засгийн газрын 2010 оны 140 дүгээр тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал"-ын газрын эзэмшил, ашиглалттай холбоотой асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгав. | Энэхүү ажилтай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/25 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгээс Засгийн газрын 2010 оны 140, 2016 оны 154 дүгээр тогтоолоор улсын тусгай хэрэгцээний газрын байршлыг тодорхойлж, 126 нэгж талбарын иргэн, аж ахуйн нэгжүүдийн газар давхцалтай байгааг тогтоож дүгнэлт гаргасан. Үүнтэй холбогдуулан ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 03/451 тоот, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгч "Говь травел" ХХК-д 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03/576, Төв аймгийн засаг дарга Ж.Батжаргал, Төв аймгийн Сэргэлэн сумын засаг дарга Э.Энхбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/736 тоот албан бичгийг тус тус хүргүүлж, чиглэл өгсний дагуу давхцалыг арилгаж газрыг БХБЯ-ны нэр дээр шилжүүлж, тусгай хэрэгцээний зориулалтаар гэрчилгээ авсан. Төв аймгаас 22 аж ахуйн нэгжийг хэвээр үлдээх хүсэлт ирүүлсэн тул батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу зориулалтыг өөрчлөн газар олгох шийдвэрийг гаргаад байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 64 | 89 | 2019 оны 5 дугаар сарын 1-ны өдөр 20 дугаар тэмдэглэл<br>2019-05-01<br>Дугаар 2019_20 | XXX.3. . 2. Тус музейн барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техникийн нөхцөл, зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу олгож, дэмжлэг үзүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарт даалгав. | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас "Чингис хаан музей"-н зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын төсөлд санал авахаар ирүүлсэний дагуу төслийг судлан үзэж 2019 оны 10 дугаар сарын 14-ны 01/3866 тоот албан бичгээр төсөлд тусгуулах саналыг хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд Ё.Баатарбилэг, Нийслэлийн засаг дарга бөгөөд хотын захирагч С.Амарсайхан нар "Чингис хаан музей"-н ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаварыг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 2019/34, 2019/05, ЗТД-2019/03 дугаартай хамтран баталсан байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | | |
| 65 | 90 | 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр 23 дугаар тэмдэглэл<br>2019-05-22<br>Дугаар 2019)23 | YII.2. . "Монголын ипотекийн корпораци ОССК" ХХК-ийн орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны арилжааны орлогоос орон сууцны зээлийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авахыг Монголбанк (Н.Баяртсайхан), Санхүүгийн зохицуулах хороо (С.Даваасүрэн)-нд зөвлөж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт даалгав. | Барилга, хот байгуулалтын яамны хүсэлтийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 онд хийх төлөвлөгөөт шалгалтын хуваарьт оруулж, II улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 30% | | |
| 66 | 91 | 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл<br>2019-05-29<br>Дугаар 2019_24 | XX.8. . Байгалийн түүхийн музейн шинэ барилгын ажлын явцын талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Байгалийн түүхийн музейн шинэ барилга барих газрын шүүхийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх, тус музейн барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарт үүрэг болгов. | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас "Чингис хаан музей"-н зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын төсөлд санал авахаар ирүүлсэний дагуу төслийг судлан үзэж 2019 оны 10 дугаар сарын 14-ны 01/3866 тоот албан бичгээр төсөлд тусгуулах саналыг хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд Ё.Баатарбилэг, Нийслэлийн засаг дарга бөгөөд хотын захирагч С.Амарсайхан нар "Чингис хаан музей"-н ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаварыг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 2019/34, 2019/05, ЗТД-2019/03 дугаартай хамтран баталсан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | | |
